

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-15
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	16-57
	1. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөл өргөн мэдүүлсэн Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан/	19-39
	2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	39-47
	3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	47-55
	4. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	55-56
	5. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	56-57

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 13-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 27 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг;
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг;
Тасалсан: Э.Бат-Амгалан.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Х.Нямбаатар нар санал хэлэв.

Нэг. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөл өргөн мэдүүлсэн Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Б.Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно гэж заасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Ц.Мөнх-Оргил, Д.Ганбат, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар нарын тавьсан асуултад Шүүхийн зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Б.Ундрах нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Ц.Мөнх-Оргил нар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Ганбат нарын гаргасан, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх Шүүгч “10” гэснийг “18” гэж өөрчлөх, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх Шүүгч “11” гэснийг “15” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Ганбат нар үг хэлж, Шүүхийн зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Б.Ундрах нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, мөн газрын Захиргаа, удирдлагын газрын дарга Д.Мөнхбаатар, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Солонго, Хуулийн мэргэжилтэн Б.Эрдэнэбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Т.Нарантунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 40.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.3.Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн цахим виз, оршин суух үнэмлэх хэвлэх үйлчилгээний хөлсний орлогыг байгууллагын цахимжуулалт, мэдээллийн технологийн шинэчлэл, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 41.1 дэх хэсгийг доор дурдсаар өөрчлөн найруулж, 41.1, 41.2 дахь хэсэг болгох:

“41.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хууль болон холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангахад төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллага мөн.

41.2.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь төрийн тусгай албан хаагч байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн тайлбарыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.14.2 дахь заалтын “шадар зөвлөх” гэснийг “эрхэлсэн зөвлөх” гэж, 41.14.3 дахь заалтын “жинхэнэ зөвлөх” гэснийг “ахлах зөвлөх” гэж өөрчилж, 41.14.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.16 дахь хэсгийн “цолд хамаарах албан тушаалын ангилал,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.17 дахь хэсгийн “Албан хаагчийн” гэснийг “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн” гэж, “мэргэжлийн, эрдмийн” гэснийг “докторын, мэргэжлийн” гэж өөрчилж, “нэмэгдлийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын саналаар хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 40.3 дахь хэсгийн “иргэн, харьяатын” гэснийг “иргэний” гэж, 41.18 дахь хэсгийн “оногдуулах” гэснийг “ногдуулах” гэж, 3 дугаар зүйлийн “Улсын байцаагч” гэснийг “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч” гэж, “41.7.2.” гэснийг “41.8.1.” гэж, “41.7.3” гэснийг, “41.8.2.” гэж, “41.7.4.” гэснийг “41.8.3.” гэж, “41.7.6.” гэснийг “41.8.4.” гэснийг, “41.7.2.” гэснийг, “41.8.2.” гэж, “41.7.3.” гэснийг “41.8.3.” гэж, “41.7.4.” гэснийг “41.8.4.” гэж, “41.7.6.” гэснийг “41.8.6.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Гадаад иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт, 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийн “төрийн тусгай хамгаалалт,” гэсний дараа болон 57.5.4 дэх заалтын “гаалийн байгууллагын ажилтан” гэсний өмнө “гадаадын иргэн, харьяат,” гэж, 13.1.6 дахь заалтын “шинжээч, мэргэжилтэн” гэсний дараа “, гадаадын иргэн, харьяатын байгууллагын ажилтан” гэж нэмэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрх зүй, эрсдэлийн удирдлагын газрын дарга Ч.Ариунхур, мөн газрын хуулийн ахлах мэргэжилтэн Ё.Отгонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.34, 6.35, 6.36, 6.37, 6.38, 6.39, 6.40, 6.41, 6.42, 6.43, 6.44, 6.45, 6.46, 6.47, 6.48, 6.49, 6.50, 6.51, 6.52, 6.53, 6.54, 6.55, 6.56, 6.57, 6.58, 6.59, 6.60 дахь заалт нэмсүгэй:

6.34.авто замын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 10.30, 11.2, 14.4, 14.5 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.35.автотээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 14.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.36.байгаль орчны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 2.1, 2.2 дахь заалт, 3, 4, 5, 6 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 4, 5, дахь хэсэг 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7 дахь заалт, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28 дахь хэсэг, 6.24 дүгээр зүйл, 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.37.барилгын техникийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 7.7 дахь заалт, 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 16.5 дахь заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 10.30, 11.2, 12.1, 12.4, 12.5, 12.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.38.боловсролын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.19 дүгээр зүйл, 9.1, 9.2, 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 9.9 дүгээр зүйл, 9.10 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, 3 дахь хэсэг, 9.11, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил;

6.39.газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйл, 7.2 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 8.1, 8.2 дугаар зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 10.30, 11.2, 12.2, 12.3, 12.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.40.газрын тос, хийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.13 дугаар зүйлийн 3, 7, 8 дахь хэсэг, 16.5 дахь заалт, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2.2, 2.3, 2.4, 2.5, 3.1, 3.3 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.41.геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.12 дугаар зүйл, 5.15 дугаар зүйлийн 1.2, 1.4 дэх заалт, 2 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 8 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 9.7 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.42.мал үржлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.43.мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 4, 5 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4 дүгээр зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 13.5, 13.9 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.44.нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.17, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.45.соёлын хяналтын улсын байцаагч Зөрчийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 9.5, 9.6 дугаар зүйл, 9.7 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14 дэх хэсэг, 9.12, 9.13 дугаар зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.46.соёлын өвийн хяналтын улсын байцаагч зөрчлийн тухай хуулийн 9.7, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.47.ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 13.1, 13.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.48.усан замын тээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.49.харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.22, 10.25, 10.27, 10.29, 10.30, 11.2, 14.1, 14.2, 14.3, 14.13 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчил;

6.50.хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.2, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.51.хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 10.12, 10.13, 10.14 дүгээр зүйл, 10.15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 10.16, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.52.хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.15, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.53.хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.3 дугаар зүйлийн 2.3, 2.4 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 14, 15, 16 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.16 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, 6.25 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25, 13.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.54.хэмжил зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.24, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.55.цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 12.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.56.эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 1.2, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.9 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.57.эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.8, 6.9 дүгээр зүйл, 6.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 6 дахь хэсэг, 6.11 дүгээр зүйл, 6.7 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсэг, 9.2, 9.4 дэх заалт, 6.9 дүгээр зүйл, 6.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 6 дахь хэсэг, 6.11 дүгээр зүйл, 6.28 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.58.эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6 дахь заалт, 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 3, 6 дахь хэсэг, 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6 дахь заалт, 8, 9, 10, 12, 13, 14, 15, 17, 18, 19, 20, 23, 26 дахь хэсэг, 6.2 дугаар зүйлийн 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг, 6.3 дугаар зүйл, 6.4 дүгээр зүйлийн 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.7, 2.9 дэх заалт, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11, 16 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.9 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэг, 6.12 дугаар зүйл, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.17 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1.1, 1.5 дахь заалт, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 6, 8 дахь хэсэг, 9.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4 дүгээр зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 1.9, 6.1, 7.2 дахь заалт, 12.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12.5 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.59.эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.19, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.60.эрчим хүчний хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 10.30, 11.2 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 7.2 дахь заалт, 12.8, 12.9, 12.10, 12.12 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.11 дэх заалтын “6.1 дүгээр зүйлийн 27” гэсний дараа “, 28” гэж, 6.12 дахь заалтын “7.5 дугаар зүйл,” гэсний дараа “7.10, 7.11, 7.12, 7.13,” гэж, “6.5 дугаар зүйлийн 10, 12,” гэсний дараа “13,” гэж, “6.17 дугаар зүйлийн” гэсний дараа “5,” гэж, “7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,” гэсний дараа “7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж, 6.14 дэх заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.15 дахь заалтын “10.19 дүгээр зүйл,” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх.

“4 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаатар: Төслийн 3 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын Ц.Сандаг-Очир танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Мөнхбаатар: “Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 55 минут үргэлжилж, 19 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Л.МӨНХБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг эрье.

Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу ирцийг танилцуулъя.

Л.Мөнхбаатар ирсэн, С.Бямбацогт гишүүн ирсэн, Д.Ганбат гишүүн ирсэн, Б.Дэлгэрсайхан гишүүн ирсэн, Ц.Мөнх-Оргил гишүүн ирсэн, Х.Нямбаатар гишүүн ирсэн, Б.Пүрэвдорж гишүүн ирсэн, Ш.Раднаасэд гишүүн ирсэн, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, Ж.Сүхбаатар гишүүн ирсэн, Ц.Сэргэлэн гишүүн ирсэн, Н.Учрал гишүүн ирсэн, Б.Энх-Амгалан гишүүн ирсэн, Б.Энхбаяр гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 4 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт нь, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын дотоодын төсөл. Шүүхийн ерөнхий зөвлөл өргөн мэдүүлсэн. Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан ийм төсөл байна.

Хоёрт нь, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2012 оны 09 сарын 29-ний өдөр Төрийн хянан шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Гуравт, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022 оны 10 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Дөрөвт нь, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Энэ нь болохоороо Засгийн газар өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Тавдугаарт нь, Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орьё. Ш.Раднаасэд гишүүн горимын санал гаргая. Ш.Раднаасэд гишүүний микрофоныг өгье.

Ш.Раднаасэд: Харьяатын хуулийн төслийг хоёр дахь асуудал болгоод хэлэлцээд өгөөч. Би яаралтай. Ажлын хэсэг учраас юмыг нь танилцуулчихъя. Яаралтай энд бас хажууд зэрэгцүүлээд ажил хийчихдэг.

Л.Мөнхбаатар: Тэгвэл хоёр дахь асуудал дээр Гадаадын иргэн, харьяатын хуулийг оруулаад тавьчих.

Х.Нямбаатар гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлье.

Х.Нямбаатар: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Сүхбаатарын талбайд жагсагчид маш олон шаардлагууд тавьж байгаа. Үүний нэг нь энэ авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлээ эрх баригчид, хууль тогтоогчид чангатгаач ээ гэдэг шаардлага биелэгдээгүй. Өнгөрсөн 4 сарын жагсаалын.

Тэгээд энэ бол Эрүүгийн хуулийн албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогод өөрчлөлт оруулж, тэр дундаа хэрэг хялбаршуулсан журмаар шийдэхгүйгээр ердийн горимоор ял оногдуулдаг ийм өөрчлөлтийг оруул гэдэг шаардлага тавьж байгаа.

Үүнийг шийдэх эрх нь мэдээж хэрэг Байнгын хороо, чуулганы асуудал байгаа.

Засгийн газрын зүгээс өчигдөр жагсагчидтай уулзахдаа ямар байр суурь илэрхийлсэн бэ гэхээр энэ асуудлыг энэ долоо хоногтоо яаралтай горимоор оруулъя гэдэг ийм зүйлээ хэлсэн.

Ийм гурав, дөрвөн хуулийг маргааш Засгийн газрын хуралдаанаар оруулаад маргааш Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэхээр байгаа.

Нэг нь, Эрүүгийн хуулийн зөвхөн 22-той холбоотой.

Хоёр дахь нь, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, хуулийн зөвхөн нөгөө ял шийтгэл оногдуулахтай холбоотой журам.

Дараагийн дугаарт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж аж ахуйн шинж чанартай гэрээ хэлцэл хийх талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл цаашид зөвлөмж гаргаж байхгүй гэдэг.

Төрийн болон албаны нууцын тухай хуульд аж ахуйн шинж чанартай гэрээг төрийн болон албаны нууцад хамааруулахгүй байх гэсэн ийм хэдэн хуулийн өөрчлөлт, нэмэлт өөрчлөлтийн төслүүдийг өргөн барьж байгаа.

Тэгэхээр маргааш үүнийг өргөн бариад тэгээд Их Хурлын дарга, даргын зөвлөл хуралдах байх гэж бодож байна.

Би одоо юу хэлэх гэж байна вэ гэвэл бид нар эрүүгийн эрх зүй, ер нь нийтийн эрх зүйн чиглэлээр ерөөсөө л уламжлагдсан шинэчлэл хийгдээд явж байгаа.

Дөнгөж сая би бас Ц.Мөнх-Оргил гишүүнд үзүүлж байна.

Одоо Д.Ганбат даргыг Хууль зүйн байнгын хорооны дарга байх үед л эхэлсэн Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн шинэчлэлийн ажил цаашаага тасралтгүй үргэлжлээд явж байгаа. Энэ бол нэг их тийм улс төржих сэдэв биш.

Одоо өнөөдөр Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих ангиудад 4 мянга 100 орчим ялтан ялаа эдэлж байна. Мянга гаруй хоригдогч буюу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байна. Урьд нь энэ статистик 2002 оны Эрүүгийн хууль батлагдсанаас хойш дунджаар 7 мянга гардаг байсан.

Тэгээд 2000 оны Эрүүгийн хуулиас хойш 2008 он хүртэл, 2015 он хүртэл нийтдээ 4 удаа өршөөл үзүүлж байж дунджаар 5 мянгад хоригдогчийн тоо баригдаж байсан.

Тэгэхээр манай Д.Ганбат даргыг Хууль зүйн байнгын хорооны дарга байх үед эхлүүлсэн энэ эрүүгийн эрх зүйн шинэчлэл их зөв явж байна гэдгийг бас хэлмээр байгаа юм.

Тэгэхээр цаашид бид энэ Эрүүгийн хууль дээрээ тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулж, энэ 5 жил гаруйн хугацаанд хэрэгжилтийн явцад жижиг сажиг засаж залруулах зүйлүүд байгаа. Энэ койнттой холбоотой, виртуал хөрөнгөтэй холбоотой, одоо хамгаалалт тогтоох ийм харилцаанууд байгаа учраас өмнө нь өргөн барьсан, хэлэлцэх эсэхээ шийдсэн энэ төслийг юутай нь өргөн бариад ингээд ажлын хэсэг нь ажиллаж баймаар байна.

Одоо бид нар эхний ээлжид нөгөө яаралтай жагсагчид шаардсан хүрээндээ нөгөө том төслөө унагаачихгүй үүднээс зөвхөн тусад нь авлига, албан тушаалынхаа юуг өргөн барья. Нөгөө өмнө нь барьсан гурвыг маргааш дахиад

барьчихна. Дөрвөн төслөө ингээд ажлын хэсэг гаргаад анхны хэлэлцүүлэгт нь бэлтгэх ажлаа жоохон эрчимжүүлбэл яасан юм бэ гэдэг ийм саналыг Байнгын хорооны гишүүний хувьд гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Маргааш Засгийн газар тодорхой энэ ерөнхий хуулийн төслөө өргөн мэдүүлэх юм байна. Мэдүүлсний дараа даргын зөвлөлөөс шийдвэр гаргаад Хууль зүйн байнгын хороо бас яаралтай горимоор хэлэлцэх учраас хуралдаж магадгүй байгаа.

Тийм учраас гишүүд маргааш бэлэн байгаарай гэдгийг хэлье.

Маргааш Байнгын хороо, тэгээд чуулганаар хэлэлцэхээр урьдчилсан байдлаар төлөвлөж байгаа.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

Х.Нямбаатар: Ажлын хэсгээ л ажиллуулчихъя. Та ажлын хэсгээ шинэчлээд явах уу л гэж хэлээд байгаа шүү дээ.

Л.Мөнхбаатар: Тийм, тийм. Ажлын хэсгийг шинэчлэхээр Их Хурлын дарга дээр угаасаа захирамжийн төсөл орчихсон байж байгаа юм. Маргааш угаасаа өргөн барингуут ажлын хэсэг шинэчлэгдэж байгуулагдаад байх юм.

Х.Нямбаатар: Тэгэхдээ хоёр тусдаа явна шүү дээ. Нэг нь энэ долоо хоногт яаралтай горимоор. Нөгөөх нь ердийн горимоор.

Л.Мөнхбаатар: Тэгж байгаа. Явж байгаа. Бусад хуулиуд дээр ажиллах ажлын хэсэг бас ажиллаж байгаа. Тийм.

Эхний асуудлаа хэлэлцье.

Нэг. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөл өргөн мэдүүлсэн/
Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан/

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 46.3 дахь хэсэгт шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно гэж заасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан тогтоолын төслийн танилцуулгыг хийе.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/16/67 тоот татан бичгээр Монгол Улсын Их Хурлын 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай саналыг ирүүлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 42 дугаар тогтоолоор аймаг, нийслэлийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны ерөнхий шүүгч “25”, шүүгч “118” нийт “143”, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийг ерөнхий шүүгч “1” шүүгч “15”, нийт “16”, дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд ерөнхий шүүгч “9”, шүүгч “93”, нийт “102”, дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд ерөнхий шүүгч “9”, шүүгч “79”, нийт “88”, Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд ерөнхий шүүгч “22”, шүүгч “82”, нийт “104”, сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд ерөнхий шүүгч “21”, шүүгч “99”, нийт “120”, сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд ерөнхий шүүгч “21”, шүүгч “66”, нийт “87”, сум дундын шүүхэд ерөнхий шүүгч “8”, шүүгч “31”, нийт “39” байхаар заасан бөгөөд Монгол Улсын хэмжээнд “699” шүүгч ажиллахаар тогтоосон.

Өнөөдрийн байдлаар 486 шүүгч ажиллаж байгаа буюу 203 шүүгч дутуу ажиллаж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгчийн ажлын ачааллыг судлах зарилгаар 2017 оноос 2021 он хүртэл буюу сүүлийн 5 жилийн улсын хэмжээнд шүүн таслах ажиллагааны статистик үндэслэсэн судалгаа хийсэн бөгөөд нийслэлд үйл ажиллагаа явуулдаг анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн ачаалал, бусад шүүхүүдийн ачааллаас өндөр байгаа хэдий ч орон тоо дутагдалтай байгаа дүн гарсан байна.

Тодруулбал, Монгол Улсын хэмжээнд анхан шатны шүүх хүлээн авсан нийт эрүү, иргэн, захиргааны хэргийн 60-аас 65 хувь, шийдвэрлэсэн хэргийн 55-аас 58 хувийг нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа шүүхэд шийдвэрлэсэн судалгаа байгаа бөгөөд энэ тоо жил ирэх тусам нэмэгдэж байна.

Тухайлбал, Улсын Их Хурлын 2016 оны 42 дугаар тогтоолоор Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо “17” байхаар тогтоосныг “27”, Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо “16” байхаар тогтоосныг “21”, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо “11” байхаар тогтоосныг “19”, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгчийн орон тоо “14” байхаар тогтоосныг “20”, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоо “15” байхаар тогтоосны “21” хүртэл нэмэгдүүлэх шаардлага байгааг судалгааны дүн харуулсан байна.

Иймд зарим аймгийн сум дундын эрүүгийн болон иргэний хэргийн анхан шатны шүүх, зарим сумд дахь сум дундын шүүхийн шүүгчийн сул байгаа орон тоог хасаж, ачаалал ихтэй байгаа нийслэлийн зарим дүүргийн шүүхэд нэмэх байдлаар ачааллыг бууруулах боломжтой байна.

Шүүхийн ажлын ачааллыг тэнцвэржүүлснээр хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх нөхцөл бүрдэх төдийгүй иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд бодит үр дүнгээ үзүүлнэ гэж үзсэн учраас Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд дүүргийн эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийг 19-өөр нэмэгдүүлж, зарим аймгийн сум дундын эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүх, сум дундын шүүгчийн 19 сул орон тоог хасахаар боловсрууллаа.

Сул орон тоог шилжүүлж байгаа буюу шүүгчдийн хөдөлгөөн хийгдэхгүй учраас зардал гарахгүй бөгөөд шүүгчийн нийт орон тоо нь тооны хувьд өөрчлөгдөхгүй, шүүгчийг шилжүүлэх, чөлөөлөх асуудал үүсэхгүй юм.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээ болон нэмэгдэл олгох журам, шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтанд саналаа ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж, санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасныг баримтлан Монгол Улсын Их Хурлын 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд. Ажлын хэсгийг танилцуулаад орхиё.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя Шүүхийн зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Б.Ундрах нар оролцож байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлж, асуулт асуух гэсэн юм байна уу? Хэн байна? Ж.Сүхбаатар гишүүнээр тасаллаа.

Б.Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Шүүхийн орон тоог шинэчлэн батлах тухай Их Хурлын тогтоол орж ирж байна.

Тэгээд сая Байнгын хорооны дарга энд ингээд шүүгч нарын тоо нэмэгдэхгүй, цалин нэмэгдэхгүй, нааш цаашаа нүүдэл суудал хийхгүй ингээд хооронд нь зохицуулаад болж байгаа юм гэсэн тайлбар хийчихлээ л дээ.

Тэгээд энэ дээрээс ингээд хараад байхаар зэрэг нийт шүүгч 90 гэснийг 106 болголоо гээд тоо нь нэмэгдэж харагдаад байх юм. Шүүгч гэснийг “14” байсан нь “17” болголоо гээд ингээд.

Тэгээд ингээд харахаар зэрэг тооны үзүүлэлт нэмэгдчихсэн.

Хоёр дахь нь, сум дундын шүүхийн шүүгч нараа бол ингээд хасаад хасаад явчхаж байгаа юм л даа. Говь-Алтай “4” гэснийг “3”, Говьсүмбэр “3” гэснийг “2” гээд л. Дундговь “4” гэснийг “3”, Өмнөговь “4” гэснийг “3” гээд л. Булган аймаг “3” гэснийг “2” гээд л.

Тэгсэн хэрнээ хотынхоо дүүргүүд дээр ингээд нэмээд нэмээд нэмээд явчхаж байна л даа. “13” гэснийг “16”, “16” гэснийг “19” гээд.

Үүний шалтгааныг нь тайлбарлаадхаач. Хөдөө орон нутагт эрүүгийн хэргийн нөхцөл байдал тийм сайхан нааштай болчихсон юм уу? Яагаад хөдөө орон нутгаас тэнд чинь ажиллах хүн олдохгүй байхад чинь тэндээсээ хасаад хот дээр авчирч нэмээд байгаа юм? Үүнийг сайн ойлгосонгүй. Энд нэгэн хариулт өгөөдөхөөч.

Л.Мөнхбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Б.Ундрах уу? 2 номер микрофоныг өгье.

Б.Ундрах: Баярлалаа. Бүгдэд нь өдрийн мэндийг хүргэе.

Саяын асуултад хариулъя. Их Хурлын 42 дугаар тогтоолоор нийт шүүгч нарын тоо 699 байгаа.

699 байгаа ч гэсэн яг энэ хэмжээндээ ажиллахгүй. Яг өнөөдрийн байдлаар 486 шүүгч ажиллаж байгаа. Төсөвт тусгаснаар 524 байгаа. Тэгэхээр буураад, нэмээд, хасагдаад байна гэдэг нь бид 699 дотроо энэ хөдөлгөөнийг хийж байгаа л гэж ойлгож болно.

Тэгэхээр хэрвээ дүүрэгт нэмэгдэж байгаа бол саяын хасагдсан гээд байгаа орон нутгаас шүүгч нарын тоог буураад дүүрэгтээ нэмэгдэж байгаа. Энэ бол ачааллаасаа хамаараад зарим газрынх нь орон тооноос дүүрэг рүү нэмж байгаа.

Хэдий нэмж байгаа ч гэсэн яг тухайн орон тоон дээр аль нэгэн, ямар нэгэн шүүгч ерөөсөө ажиллахгүй байгаа гэсэн үг. Одоохондоо сул оронтой байгаа л гэсэн үг л дээ.

Жишээлбэл, аль нэг сумын шүүхэд 6 орон тоо 42-оор батлагдсан бол өнөөдрийн байдлаар 4 ажилладаг. 2 дээр нь хүн ажилладаггүй. Тэрийг нь хот руу татсан л гэсэн үг.

Ийм байдлаар хийсэн байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ц.Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ тогтоолын төслийг оруулж ирэхдээ яг нэг шүүгчид оногдох хэрэг, тогтоол шийдвэрийн тоог тэнцвэржүүлж оруулж ирж байна гэж би ойлгож байгаа. Тэрийг нэг тайлбарлаадхаач. Яг яаж тэнцвэржүүлэв ээ?

Жишээ нь, тэр тэнцвэржүүлэх дотор хэргийн тооноос гадна тэр хэлэлцэж байгаа асуудлын мөн чанар, үнийн дүн, адармаатай байдал, эд нарыг бас харгалзмаар байгаа байхгүй юу? Тийм ээ. Жишээ нь, иргэний шүүх дээр гэхэд Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дээр хамгийн үнийн дүн өндөртэй. Манай шүүхийн практикт харьцангуй шинэлэг, төсөв, хөрөнгө санхүү, татвар, үнэт цаасны маргаан гээд шинэлэг асуудлууд их байгаа шүү дээ. Энэ чинь өөрөө бас тэр тооцоонд орох ёстой юм л даа. Тэгээд зөвхөн тэр хэргийн тооноос гадна энэ хэргийн хэлэлцэгдэж байгаа асуудлуудын чинь хүндрэл, мөн чанар, үнийн дүн бас орж байх ёстой юм л даа. Тэгээд үүнийгээ тусгасан юм уу?

Жишээ нь, Чингэлтэй, Хан-Уул эд нар хэчнээн нэмсэн ч гэсэн нөгөө дүүргүүдийнхээ тоонд хүрэхгүй л байна шүү дээ. Иргэний хэрэг дээр бол. Жишээ нь. Тийм ээ. Үүнийг нэг тайлбарлаад өгөөч. Тэгээд би дараа нь саналтай байгаа.

Л.Мөнхбаатар: Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. 3 номер уу? 3 номерын микрофоныг өгье. А.Насандэлгэр гишүүн.

А.Насандэлгэр: А.Насандэлгэр гишүүн байна.

Тийм. Гишүүний ойлголтыг би нэгдүгээрт зайлшгүй шаардлагатай, асуух ёстой ийм асуулт байлаа.

Хоёрдугаарт, бидний судалгаа хийж оруулж ирж байгаа энэ ажиллагаатай бас хамаатай байна гэж ингэж ойлголоо.

Тэгэхээр бид Шүүх байгуулах тухай хуулийн өөрчлөлтийн санал. Дээр нь энэ шүүгчийн орон тоотой холбоотой судалгаа хийлгэсэн. 2022 онд. Хөндлөнгийн байгууллагын. Энэ судалгаан дээр сая гишүүний ярьдаг энэ үзүүлэлтүүдийг гаргасан байгаа. Тухайлбал, сүүлийн 5 жилээр шүүгчийн ачааллын судалгааг гаргасан. Энэ ачааллын хөндлөнгийн судалгааг бататгахын тулд өөрийнхөө нөөц бололцоон дээр тулгуурлаад шүүгч нарын ажиллагааны судалгааг гаргасан байгаа. Энэ ажиллагааны судалгаан дотор хэрэг уншилтын судалгаа, асуумж. Дээр нь ажлын байрны зураг авалтын судалгааг гаргасан юм.

Тэгээд зураг авалтаар энэ дүүргүүдийн шүүхүүд дээр нэмж байгаа энэ тоонууд ачааллынхаа хүрээнд зайлшгүй нэмэх шаардлага нь дүүргүүд дээрээ байна. Өөрөөр хэлэх юм бол хэргийн өнгөөсөн шалтгаалаад ч нэмэх шаардлага байна, ачааллаасаа шалтгаалж хэргийнхээ тооноос хамаараад ч гэсэн нэмэх шаардлага байна гэдэг дүн гарсан учраас энэ судалгааны дүн дээр үндэслээд бид нар шүүгчийн тоо нэмэх шаардлагатай байна гэсэн судалгааны дүн гарсан.

Тэгээд яг энэ удаад бид 42 дугаар тогтоолд өөрчлөлт оруулахдаа жишээлэх юм бол Хан-Уул дүүргийн шүүх дээр 42 дугаар тогтоолоор 11 шүүгч ажиллаж байна. Судалгааны дүнгээр 19 шүүгч ажиллах ёстой гэсэн ийм дүн гарч байгаа юм.

Гэхдээ бид төсөвт хүндрэл учруулахгүйн үүднээс одоогийн байгаа багтаамж, ажлын яг нөгөө орчноосоо хамаараад энэ удаад 5 шүүгч нэмэхэд бололцоотой юм байна гэдэг байдлаар Шүүхийн ерөнхий зөвлөл хуралдаанаар хэлэлцээд ингээд оруулж ирж байгаа.

Хэрвээ Байнгын хорооны хуралдаан дээр хэлэлцээд яг ачааллынхаа хэмжээнд судалгааныхаа дүнд таарсан хэмжээнд өөрчлөлт оруулах боломжтой гэж үзвэл бид нарын яг судалгааны дүн бас бэлэн байна.

Дүүргийн шүүхүүд дээр нэмэх шаардлагууд нь судалгааны дүнгээс үндэслээд гарч байгаа юм.

Энэ дотор нөгөө бага үнийн дүнтэй хэрэг. Мөн саяын гишүүний хэлдэг ээдрээ түвэгтэй, хугацаа шаарддаг, олон хавтастай, нотлох баримт цуглуулах шаардлагатай ийм хэргүүд, хялбаршуулсан журмаар хийгдэж байгаа хэргүүд, энгийн хэргүүд гээд бүх хэргүүдийн хэргийн өнгө байдлаас нь шалтгаалаад судалгаанууд ингээд гарчихсан байж байгаа. Түүнд үндэслэсэн тоонууд байгаа.

Үндсэндээ судалгаанд саяын гишүүний хэлээд бүгд хамаарна гэсэн үг.

Л.Мөнхбаатар: Тодруулъя. Үүн дээр бас ажлын хэсгээс нэмж хариулж болно.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Судалгаагаараа үүнээс ч илүү нийслэл дээр нэмэх ёстой юм байна, дүүрэг дээр нэмэх ёстой юм байна гэсэн тоо гарчхаад байна шүү дээ. Тийм ээ.

Энэ ажлын зураг авалтаар бол. Надад ийм асуулт байна. Жишээ нь, та нар ингээд Говьсүмбэр дээр 4 байгааг 3 болгоод оруулаад ирлээ. Одоо тэртээ тэргүй 3 ажиллаж байгаа юм гээд тэгж байна шүү дээ. Яг түүнтэй адилхан хасагдаагүй аймгуудаас чинь дутуу нөхөгдөөгүй орон тоонууд байна уу? Жишээ нь, юу гэдэг юм. Дундговьд 4 гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр Говьсүмбэрийн 4, Дундговийн 4 хоёр бол ер нь ойролцоо л байх ёстой гэж зүгээр нүдэн баримжаагаар л бодоод байна л даа.

Одоо Дундговийн 4 шүүгч нь 4-үүлээ ажиллаж байна уу, 3 байна уу? Жишээ нь. Яг иймэрхүү тоотой адилхан тоонууд байна уу? Аймгууд дээр.

Л.Мөнхбаатар: А.Насандэлгэр гишүүн хариулъя. 3 номерын микрофон өгөөрэй.

А.Насандэлгэр: Байгаа. Яагаад үлдчихсэн юм гэхээр бид нар энэ удаад анхан шатны шүүхүүд тэр 19 шүүгчийн сул орон тооны хөдөлгөөн л хийж байгаа юм.

Цаашдаа бид 26 болгоё, 27 болгоё гэвэл үлдсэн нь Дундговиосоо авах боломж нь цаана нь байна л гэсэн үг.

Гурвуулаа ажиллаж байна. Цаана нь сул орон тоо гэсэн үг. Тийм.

Ер нь аймгууд дээр бол иймэрхүү л байгаа.

Л.Мөнхбаатар: Сая та нар 19 шүүгчийн орон тоог л гаргаж ирээд байна шүү дээ. Түүнээс өөр байгаа юм уу л гэж Ц.Мөнх-Оргил гишүүн асуугаад байх шиг байна. Тийм ээ.

А.Насандэлгэр: Зүгээр нэмэх нь давж заалдах шатны, нөгөө Иргэний давж заалдах шүүх дээр нэг орон тоо байгаа. Ингээд нийтдээ 20 орон тоо л байгаад байгаа юм. Хөдөлгөөн. Сул орон тооны хөдөлгөөн.

Л.Мөнхбаатар: Тэрнийхээ 19-ийг нь оруулж ирсэн юм байна шүү дээ. Тийм ээ.

А.Насандэлгэр: Анхан шатны л гэж бичсэн. Тодотгож бичсэн.

Л.Мөнхбаатар: Анхан шатны гэж. Б.Ундрах гишүүн нэмж хариулах уу? 2 номер.

Б.Ундрах: Яг саяын асуулттай холбоотойгоор ер нь бид нар судалгаа гэж яриад байгаа нь ямар учиртай вэ гэхээр бид нарт 42 дугаар тогтоолоор нэг тоо

байна. Одоо ажиллаж байгаа шүүгч нарын нэг тоо байна. Судалгааны нэг тоо байна.

Судалгааны тоогоор харах юм бол хамгийн шүүгч шаардлагатай байгаа эдгээр 5 иргэний хэргийн анхан шатны шүүхийн хувьд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул байгаа юм.

Энэ дотроо арай эд нар луугаа дөхүүлээд тоог нь нэмэх ийм боломж байна гэж харах юм бол орон нутгаас хэрвээ орон тоо авах юм бол хамгийн бага ачаалалтай тоог нь л авна гэсэн үг. Бага ачаалалтай шүүхээс сонгохдоо тэнд аль нэг шүүгч ажиллаагүй шүүхээс нь сонгоно л гэсэн үг л дээ. Зарчим нь адилхан гэсэн үг. Тийм.

Л.Мөнхбаатар: Тайлбар ойлгомжтой байна. Д.Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Маш чухал асуудлыг бид нар хэлэлцэж байна л даа. Яагаад гэвэл иргэд шүүхээр хэл амгүй, хурдан асуудлаа шийдүүлэх ийм эрхтэй.

Тэгээд шүүхийн асуудал бол маш хүнд байгаа. Тэгээд ер нь нэг шүүгч дээр ямар ачаалалтай байна. Иргэний хэргийн нэг шүүгч хэдэн хавтаст хэрэгтэй байна вэ? Улаанбаатарт хүн амын бараг 50, 60 хувь нь байна. Бараг үл хөдлөх хөрөнгийн нэлээн их хувь нь үнийн дүнтэй ийм үл хөдлөхүүд байж байна.

Тэгээд төсөв мөнгө хэмнэнэ, шүүгчийн тоо байх ёстойгоосоо бага байгаа энэ тэр гээд тиймэрхүү юм яриад байх юм. Үүний цаад талд чинь иргэд шударга шүүхээр хэргээ шийдүүлэх, хуулийн хугацаанд эрхээ хамгаалуулах гээд ийм олон асуудал байгаа шүү дээ. Тэгээд нэг шүүгч, шүүхийг нэг үлдэгдэл юмаар санхүүжүүлдэг. Ийм маягаар ингээд олон жил явдаг. Тэгээд шүүхийн нэр хүнд уландаа орчихсон ийм нөхцөл байдалтай байна. Шүүхийн ерөнхий зөвлөл би бас учир дутагдалтай ажиллаж байна уу л гэж бодоод байгаа юм. Та нар яг ямар судалгаан дээр ингэж оруулж ирж байна?

Тэгээд шүүхийн нэр хүнд чинь унаад байна. Анхан шатны 400 хэдхэн шүүгч чадлаараа ажиллаж байгаа гэж бодож байгаа. Аль 2012-2016 онд л бид энэ асуудлыг шийдвэрлээд тойргийн шүүх байгуулъя гээд санал оруулаад явж байсан. Гэтэл нөгөө л Монгол Ардын намын авлигачид.

Би одоо бас ахиад л хэлэх нь. Уучлаарай. Тэд нар тойргийн шүүх байгууллагыг эсэргүүцээд. Яагаад гэвэл хууль, шүүхийн систем өөрийнхөө сүлжээг унагаахгүйн тулд ингээд барьж явсаар байгаад эцсийн эцэст ард түмний бухимдлыг дээд цэгт нь хүргэчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд ийм судалгаа, тооцоо юмнууд байна уу?

Тэгээд Хан-Уул дээр гэхэд л 11 байгааг 16 болголоо гээд байх юм. Үгүй ээ, тэр 18, 19-д нь хүргээд л оруулаад ирээч дээ. Тэр Хан-Уул чинь өдөр болгон л

өсөөд байна. Тэр хүмүүсийн хэргээ шийдүүлэх эрх нь. Тийм. Болохгүй бол одоо би санал гаргая.

Та нар одоо яг ямар судалгаан дээр яаж ингэж оруулж ирж байна аа? Энэ аргагүй хүнд нөхцөл байдлаа Шүүхийн ерөнхий зөвлөлд танилцуулаад ярих хэрэгтэй шүү дээ. Ойлгуулах хэрэгтэй шүү дээ. Олон түмэнд. Энэ Улсын Их Хурлын гишүүдэд ч гэсэн.

Тэгээд нөгөө гурав дахь засаглалын нэг болох шүүх засаглал чинь байхгүй болчихоод байна шүү дээ. Үндсэндээ. Үүнийг л бид нар яриад байгаа.

Тэгээд энэ 42 дугаар тогтоол, энэ юмаар бол зүгээр л аргацааж байна л даа. Бид нар. Тэгээд 530 шүүгчийн орон тоо байдаг. Тэрийг нь ч ажиллуулдаггүй. 470 шүүгчтэй байдаг. Ийм хариуцлагагүй байж болохгүй шүү дээ. Яг энэ шаардлага нь хамгийн наад тал нь 700 шүүгч байх ёстой юм байна. Үүнийгээ яаж засаж янзлах юм бэ? Үүний цаана чинь иргэдийн эрх ашиг байна шүү дээ. Энэ шударга шүүхээр өөрсдөө хэргээ шийдүүлэх, хуулийн хугацаанд шүүхийн үйлчилгээ авах. Одоо шүүхгүй юм байхгүй болчихсон шүү дээ. Бүх маргаанууд шүүх дээр л очиж байна. Энэ юм дээрээ анхаарч ажиллах ёстой байх л гэсэн ийм ойлголттой байна.

Та нар нэг сайхан тайлбарлаад. Энэ олон түмэн ч сонсож байгаа байх. Энэ Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн ойлголттой болох байх. Тэгээд бид нар юмыг аргацаах маягаар аргалъя барья гээд л ингээд л өнгөрдөг. Энэ маягаараа цаашдаа яваад байж болмооргүй санагдаад байна.

Яг наадхаа тэр судалгаа шинжилгээ үндэслэлтэйгээр ингээд тайлбарлаад өгчих.

Л.Мөнхбаатар: Д.Ганбат гишүүний асуултад А.Насандэлгэр гишүүн хариулъя. 3 номерын микрофон.

Д.Ганбат гишүүний асуултад хариулахдаа бас нэмээд Шүүх байгуулах тухай хуулийн асуудал явж байгаа. Тийм ээ. Тэр талаараа бас тодотгоод хариулчихаарай.

А.Насандэлгэр: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Шүүхийн ачаалал харилцан адилгүй байгаа. Орон нутагтаа зарим газар бага байна. Энэ нийт ачааллын 50-иас 60 хувь нь нийслэлд байна. Нийслэлийн анхан шатны шүүхүүд дээр байна.

Гишүүн асуусан учраас бид нарт судалгаа байгаа. Тийм учраас судалгаагаа би дүүргийн шүүхүүдээр нь хэлчихье. Би Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачааллыг танд нэг шүүгчид ноогдож байгаа ачааллыг нь яг гаргаснаар хэлчихье.

-Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны нэг шүүгчид 358 хэрэг ногдож байна.

-Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгчид 244 хэрэг;

-Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгчид 425 хэрэг;

-Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 281 хэрэг;

-Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 362 хэрэг;

-Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 322 хэрэг.

Тэгээд төвийн 6 дүүргийн энэ ачаалал яг хийх ёстой, байх ёстой ачааллаасаа хэтэрсэн ийм хэмжээнд ажиллаж байгаа.

Тийм учраас бид шүүгчийн орон тоог нэмэх шаардлагатай байна гэдгийг судалгааны үндсэн дээр үндэслэж гаргаж байгаа юм.

2022 онд бид 2021 онд шинэчлэн байгуулагдсан Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Шүүх байгуулах, өөрчлөн байгуулах тухай хуулийн саналыг Засгийн газарт хүргүүлээд байна.

Энэ Шүүх байгуулах тухай хуулийг хүргүүлэхдээ судалгаа гаргасан гэдгийг түрүүн дурдсан. Энэ судалгаагаар Иргэний хэргийн анхан шатны шүүх жилд 209 хэрэг шийдвэл зохист ачаалал гэж үзнэ гэсэн ийм судалгааны дүн гарсан юм.

Ингээд 209 хэрэг шийдвэрлэх ёстой гэж үзэх юм бол жишээ нь Баянзүрх дүүргийн иргэний хэргийн шүүх дээр 358 хэрэг байна гэдэг бол үнэхээр хэтэрсэн ийм ачаалалтай ажиллаж байгаа ийм байдал ажиглагдаж байгаа юм.

Тийм учраас бид орон нутагт байгаа сул орон тоонуудаа дүүрэг рүү шилжүүлэх байдлаар энэ ачааллын дүн судалгаанд үндэслэсэн байдлаар шилжүүлж тогтоолд өөрчлөлт оруулж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Ш.Раднаасэд гишүүн асуултаа асууя. Д.Ганбат гишүүн тодруулъя. Д.Ганбат гишүүн гэхдээ бас тодорхой зарчмын зөрүүтэй санал гаргах эрх нь байгаа шүү.

Д.Ганбат: Баярлалаа. Бас манай А.Насандэлгэр шүүгч олон жил шүүгч хийсэн хүн болохоор бас нэлээн сайхан тодорхой тайлбарлаж байна.

Цаг хугацаа өгөөд наад талын хоёр дахь микрофоныг ч гэсэн онгойлгоод өгчих хэрэгтэй байна. Бас хүмүүс мэдээлэл авах эрхийнхээ дагуу авсан дээрээ.

Нөгөө талаар тэмдэгтийн хураамжийн байдал чинь ямар байна. Түүгээр чинь тодорхойлж болно шүү дээ бас. Ер нь шүүгчийн ачаалал ямар байгаа юм?

Улаанбаатар хот гэхэд ямар байна? Хан-Уул дүүргийн жишээн дээр ингээд яриад өг. Хамгийн их ачаалалтай, хамгийн их мөнгө төгрөгөө төлж байгаа, иргэд хэргээ шийдвэрлэхийг хүсэж байгаа ийм газар энэ Улаанбаатар хот гэж ойлгож байна. Энэ дотроо Хан-Уул гэж ойлгож байна, би.

Тэгээд нэг шүүгч дээр ирэх ачаалал гурав, дөрөв дахин нэмэгдчихсэн байдаг. Тэгээд иргэдийн авч байгаа шүүхийн үйлчилгээ бол нөгөө шүүгч маань хэрэг ээ ч уншиж чадахгүй байна шүү дээ. Бараг. Тийм боломжгүй болчхож, ядаж. Хүн чинь тэр ачааллыг даахгүй. Тэгээд одоо энэ шүүхэд ажиллах шүүгчид ч гэсэн, хуульчид ч гэсэн багассан байна шүү дээ.

Тэр шилдэг хуульчдаа ч сонгон ядруулж чадахгүй.

Л.Мөнхбаатар: Д.Ганбат гишүүн зарчмын зөрүүтэй саналаа Б.Пүрэвдорж гишүүн гаргасантай нэгтгэж болох юм байна. Тийм ээ. Тэгээд хоёр нэгтгээд өгчих.

Хан-Уул дүүрэг дээр бас ачаалал их өндөр байна гэж гишүүд үзэж байгаа юм байна гэж ойлголоо.

Ш.Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Энэ давах шатны чинь шүүхийн ачаалал ер нь анхан шатнаасаа ямар ч байсан сул, бага л байгаа байх даа. Тийм.

Тойргийн зарчмаар байгуулах тэр юм хумаа үүнтэйгээ цуг оруулж болохгүй байсан уу? Би бол орон нутаг дахь давахын юунууд маш бага байгаа л гэж харж байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, нөгөө дутуу байгаа орон тоонуудаа хэзээ нөхөж оруулж ирэх юм? Одоо 100, 200 гаруй орчим шүүгч дутуу байгаа гэж яриад байгаа шүү дээ. Сонгон шалгаруулалт явагдаагүй.

Гуравдугаарт, орон нутгаас ингээд шүүгч нар татаад хамаагүй энд ажиллуулж болно л доо.

Энэ нөгөө байр сав нь байна уу? Одоо тэр байр савны чинь асуудал, энэ шүүгч нарын чинь суух өрөө, ядаж туслахынх нь суух өрөөнөөс эхлээд наадах чинь хэд хэдэн шүүхийн байрууд чинь аягүй хүнд юм байна лээ шүү дээ.

Ялангуяа энэ Сүхбаатар дүүргийнх энэ хойд талынх. Энэ Баянзүрх.

Б.Пүрэвдорж гишүүн ээ, Би гурван юм яриадахъя. Тэгээд Хан-Уул бол дэмий юм. Эдний саналыг л дэмжих ёстой шүү.

Энэ байр сав чинь бэлэн байгаа юм уу? Одоо ингээд шүүгч нараа энд зузаалаад байдаг. Мэдээж хэргийн ачааллаа дагаад шүүгч нарын авч түр татаад байж болно.

Энд ажиллах орчин нөхцөл нь одоо хэр байгаа юм бол? Одоо энэ шүүхүүдийн чинь байрыг харахаар зарим нь нээрээ ёстой гунигтай харагддаг юм билээ шүү. Ийм гурван асуулт байна.

Надад энэ тойргийн юмаа цуг оруулаад ирсэн бол арай илүү нэг мөр юм болох байсан юм болов уу гэж харагдах юм.

Л.Мөнхбаатар: Ш.Раднаасэд гишүүний асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн хариулахдаа бас нэлээд тодруулаад хариулчихаарай.

Шүүх байгуулах тухай хуулийг Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхтэй зөвшилцөөд, тэгээд Засгийн газраар дамжуулаад Засгийн газар өргөн барих ийм хуулийн зохицуулалттай. Тэгээд энэ ажлын явц ямар байгаа юм. Улсын дээд шүүхтэй зөвшилцөх ажил ажлын хэсэг байгуулагдсан уу, ажиллаж байна уу?

Ер нь хэдийгээр энэ хуулийн төслийг Хууль зүйн яаманд хүргүүлээд засаг өргөн мэдүүлэхээр та бүгд ярилцаж байгаа вэ? Төлөвлөж байгаа вэ? Энэ чиглэлээрээ бас нэмж тодруулаад хариулаарай. А.Насандэлгэр гишүүн хариулъя. 3 номерын микрофон өгье.

А.Насандэлгэр: Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулж байна.

Тэгэхээр энэ удаад бид яг 42 дугаар тогтоолд л нэмэлт, өөрчлөлт оруулах энэ асуудлыг хөндсөн.

42 дугаар тогтоолыг хөндөхдөө Шүүх байгуулах, өөрчлөн байгуулах тухай хуультай холбогдуулж гарах боломж байгаа. Тэгэхдээ бид Шүүх байгуулах тухай хуулийг одоо Засгийн газарт санал хүргүүлж байгаа учраас хэрэгжих хугацааг нь харгалзаад тэр хүртэл бид энэ дүүрэгт байгаа ачааллуудыг ямар нэгэн байдлаар хөнгөвчлөх байдлаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй бол болохгүй. Цаг хугацааны ийм байдал байгаа учраас зайлшгүй ингэж оруулж ирж байгаа.

Энэ оруулж ирж байгаагаа бид ачааллын судалгаан дээр үндэслэж байгаа гэдгийг сая тайлбарлалаа.

Дээд шүүх, Шүүхийн тухай хуульд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх байгуулах, өөрчлөн байгуулах хуулийг санал оруулахдаа Улсын дээд шүүхтэй зөвшилцөж санал оруулна.

Улсын дээд шүүгчтэйгээ зөвшилцсөн байдлаар саналыг Засгийн газарт хүргүүлсэн. Энэ хүргүүлж байгаа саналын хүрээнд **“тойргийн шүүхийн тухай”** асуудал яригдаж байгаа.

Тэгэхээр энэ нь Засгийн газар дээр хэлэлцэгдээд нэг мөр боогдоод орж ирэх учраас энэ талаар Шүүхийн ерөнхий зөвлөл одоо яг хэлэх боломжгүй байх. Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанаар дэмжигдсэн санал Засгийн газар луу явчихсан байгаа.

Шүүхийн ажиллаж байгаа нөхцөлийн талаар гишүүн хөндөж байна. Энэ бол үнэхээр хэцүү байгаа. Энэ бол олон жил ингэж явж байгаа учраас одоо яг миний ярих гэж байгаа зүйлийг мэдээж та бүхэн олон удаа Байнгын хорооны хурал дээр сонссон байх. Энэ талаар Та бүхнийг би бас мэддэг гэж ингэж ойлгож явдаг.

Өөрөөр хэлэх юм бол Монгол Улсын шүүх **өнөөдөр байргүй 6 шүүх байна. Түрээсийн байранд ажилладаг 8 шүүх байна.** Өөрөөр хэлэх юм бол өөрийн гэсэн байргүй ажиллаж байгаа ийм шүүхүүд олон байгаа.

Байгаа байрууд нь шаардлага хангахгүй байна. Би буруу санаагүй бол 2018 онд билүү, КОВИД-ын үеэр Хууль зүйн байнгын хорооны гишүүд Сүхбаатар дүүргийн, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн байрыг очиж үзэж байсан санагдаж байна.

Тэнд байгаа нөхцөл өөрчлөгдөөгүй хэвээрээ л байгаа. Энэ талаар Шүүхийн ерөнхий зөвлөл үнэхээр чимээгүй байдаггүй. Үе үеийн Шүүхийн ерөнхий зөвлөл өөрсдийнхөө хэмжээндээ саналаа дэвшүүлээд ингээд явдаг.

Шүүгчийн орон тооны тухайд гишүүн асуулаа. 42 дугаар тогтоолоор 2016 оноос хойш гэсэн үг. 699 шүүхтэй Монголын шүүх ажиллана гэж хэлсэн.

Энэ асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл жил жилийн төсөвтэй 699 шүүгчийн орон тооны төсвийг батлаад өгөөч ээ гэж оруулдаг.

Улсын Их Хурлаас 2020, 2021 оны шүүгчийн шүүхийн цалингийнх нь тэр сангийн тоог нь би аваад ирчихсэн байж байна.

Цалингийн сан доторх шүүгчийн эзлэж байгаа тоо нь 524 шүүгч гэж явж байгаа. Гэхдээ жилийн одоо яг энэ үйл ажиллагаа явж байгаа хугацаанд шүүгч нарын хөдөлгөөн маш их хийгддэг. Тэтгэвэрт гардаг, чөлөө авдаг, өвддөг гэх мэтээр.

Ийм хөдөлгөөнүүд хийгдээд одоогийн яг өнөөдрийн байж байгаа, ажиллаж байгаа, цалин авч байгаа шүүгчийн тоо 486 байна. Мэдээж 2022 онд 524 шүүгч ажиллуулах төсөв баталж өгсөн гэж ойлгож байгаа.

2023 оны төсөвт бид 699 шүүгчийн төсвийг боловсруулж оруулсан. 560 шүүгч байхаар төсөв баталсан гэж ойлгож байгаа. Ийм байдлаар бид нарт танилцуулсан. Сангийн яамнаас.

Тийм учраас 2023 онд бид одоогийн 486 шүүгчээ, 560 болох боломж байгаа. Тэгэхдээ үүнийг нэг жилийн хугацаанд сонгон шалгаруулалт хийгээд ажлын байрыг нөхнө гэдэг бол цаг хугацааны хувьд хэцүү байна гэдэг нь харагдаж байгаа. Гэхдээ үүнийг цаашдаа үе шаттайгаар ингээд нэмэгдүүлээд явах ийм боломж гарах байх. Яагаад гэвэл жил жилийн төсөвт суугдсан байдлаас л энэ тайлбарлагдах юм байна лээ гэж ингэж ойлгоод явж байгаа.

Л.Мөнхбаатар: Ж.Сүхбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Сүхбаатар: Баярлалаа. Бид нар урьд нь яах вэ, сая ч гэсэн ингээд хариулт дээр гарч л байгаа.

Ер нь урьд нь бид нар чинь 520 гаруй шүүгч орон тоон дээрээ ажиллаж байна. Цаана нь орон тоогоо гүйцээх нөгөө боломж, байр багтаамж байхгүй гээд л ингээд ярьж байсан. Тэгээд яах вэ, ачаалал тэнцвэржүүлж байна гэж байна л даа.

Тэгэхээр яг саяын энэ эцсийн дүнд дахиад би сонсоогүй байж магадгүй юм. Энэ тэнцвэржүүлэлтийн үр дүнд нөгөө батлагдсан үндсэн орон тоо, тэгээд одоо яг байгаа орон тоо хоёрын зөрүү дахиад хэдээр хадгалагдаж байна. Эсвэл гүйцээчих үү гэдэг нэг асуудал үүснэ.

Ер нь энэ орон тоондоо хүргэж чадахгүй байгаа асуудлыг би буруу. Түрүүн таны хэлдгээр чинь очсон хүмүүсийн нэг нь би л дээ. Тэгээд бид хэд бас нэг цалин цавуугаа авхуулаад л, ингээд бас анхаарахгүй ч биш нэг юмнууд анхаарчихсан байж байгаа.

Зүгээр байр, орон савын асуудал шийдэгдээгүй хэвээрээ байгаа.

Тэгэхээр үүнийг нэг хэлэхгүй юу? Үүний нөхцөл байдал ямар болж байгаа вэ гэж. Хуваарилалт нь эцсийн дүндээ. Ингээд тоо гүйцчихэж байна уу, эсвэл үлдэж байна уу?

Шүүх байгуулах тухай нөгөө явж байгаа юмтайгаа уялдаж байгаа юу, үгүй юу? Удахгүй нэг шүүх байгуулах тухай шийдвэрийн төсөл Хууль зүйн яаман дээр явж байгаа шүү дээ. Тэгээд түүнтэйгээ Хууль зүйн яамтайгаа уялдаад ингээд явж байгаа юу, үгүй юу гэдэг гол нь.

Л.Мөнхбаатар: Ж.Сүхбаатар гишүүний асуултад Б.Ундрах гишүүн хариулъя. 2 номерын микрофон.

Яах вэ, шүүгч нарын хувьд ийм байгаа шүү дээ. 2023 онд 80 шүүгчийн орон тоо нэмэгдэж байгаа. Гэхдээ энэ нь төсөвтөө багтаагаад явна. Сонгон

шалгаруулалт явуулахад бас тодорхой хугацаа шаарддаг. Ийм учраас жил бүр нэмэгдүүлээд явъя гэдэг зүйлийг Хууль зүйн байнгын хороо төсөв ярихдаа ярилцсан байгаа гэдгийг бас сануулаад хэлье.

Б.Ундрах гишүүн асуултад хариульъя.

Б.Ундрах: Сая ер нь үндсэндээ хариулчихлаа.

Тэгэхээр тэнцвэржүүлнэ гэдэг утгыг ямар утгаар нь хэлэх гэж байна. Ер нь өмнө нь би хэлсэн. 42 дугаар тогтоолын нийт шүүгч нарын тоо өөрчлөгдөхгүй. Харин хотод байгаа шүүгч нарын тоо нэмэгдээд орон нутагт батлагдсан орон тоо багасна л гэсэн үг. Яг үүний үр дүнд.

Харин байр савны хувьд мэдээж хүрэлцээ муутай байгаа. Гэхдээ тэрнийх нь хэрээр бид яг энэ шүүгч нарынхаа тоог нэмэхгүй байгаад байвал үнэхээр ачааллаа дийлэхгүй байгаа учраас ямар ч байсан эхний ээлжид зайлшгүй шаардлагатай нэмбэл зохилтой, ачаалал ихтэй байгаа дүүргийнхээ орон тоог эхний ээлжид зохицуульъя.

Тэр шүүх байгуулах тухай хуультай холбох буюу цаг хугацааны хувьд хүлээх нь бидний хувьд бас боломжгүй байгаа юм.

Тийм учраас хэдийгээр хуулиа өргөн барьчихсан ч гэсэн бид үүнийг эхний ээлжинд зайлшгүй хийж байя. Гэхдээ Шүүх байгуулах тухай хуультай зөрчилдөхгүй байдлаар үүнийг хийсэн байгаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүн байна уу? Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан. Х.Нямбаатар гишүүнээр тасаллаа. Х.Нямбаатар гишүүн үг хэлье.

Х.Нямбаатар: Сая Д.Ганбат гишүүний ярьж байгаа саналуудыг бүгдийг нь сонслоо.

Байнгын хороон дээр би гуравхан минутын дотор нэлээн хэдэн мэдээлэл багцлаад хэлэх гэсэн юм.

Бид өнөөдөр шүүхийн шинэчлэлийн нэг том алхам нь хийгдээгүй байгаа нь Шүүх байгуулах хуулийг Засгийн газраас Их Хуралд оруулж ирээгүй байгаа асуудал.

Энэ бол нөгөө Шүүхийн ерөнхий зөвлөл шинээр эмхлэн байгуулагдахтай холбоотойгоор энэ ажил нэлээн удааширч байгаа. Саяхан Шүүхийн ерөнхий зөвлөл саналаа Улсын Дээд шүүхэд хүргүүлсэн. Улсын Дээд шүүх манайх руу саналаа хүргүүлэх энэ ажил хийгдэж байгаа.

Бид Шүүх байгуулах хуулиар дараах хэдэн асуудлыг шийдэх гээд байгаа юм. Энэ хэргийн ачааллыг тэнцвэржүүлье. Жишээлэхэд, нэг аймгийн захиргааны хэргийн шүүх жилд дунджаар 5-аас 10 хэрэг шийдэж байгаа юм. Өөрөөр хэлбэл яг бүтэн захиргааны хэргийн шүүх. Өөрийн захиргааны албатай, бүрэлдэхүүнтэй ийм шүүх үндсэндээ 5-аас 10 хэрэг шийдэж байгаа юм.

Зарим захиргааны хэргийн шүүхүүд өөр хоорондын зай 50-иас 60 километрийн зайтай ийм. Одоо Эрдэнэт, Булган гэх мэт ингээд байрлалтай байгаа.

Тэгэхээр бид цаашид анхан шатны шүүхийг орон нутагт, эрүү, иргэний шүүхийг засаг захиргааны нэгжийг түшиглэж байгуулахаас гадна нутаг дэвсгэрийн ойр гэдэг зарчмыг харгалзаж зарим газруудад ачааллыг нь тэнцвэржүүлж тойргийн шүүх байгуулъя гэж шийдэж байгаа.

Жишээлэхэд, Багануур дүүргийг тойроод Төв аймгийн хэдэн сумдууд байдаг. Хэнтий аймгийн сумууд байдаг. Гэтэл Багануур дээгүүр даваад Зуунмодод анхан шатны журмаар хэргээ шийдүүлэх нь шударга байдаг. Багануурт газар нутгийн ойр зарчмыг баримтлаад шийдүүлбэл хэргийг маргаантай шийднэ, эргэлзээтэй шийднэ гэдэг ойлголт байж болохгүй.

Тийм учраас бид Шүүх байгуулах хуулиараа тойргийн болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн энэ зарчмуудыг түшиглэж байгуулж, зөв оновчтой энэ 699 хүнээ хуваарилъя гэдэг нэг зарчим барьж байгаа юм.

Хоёрдугаарт, давж заалдах шатны шүүхүүдийн ачааллыг нь тэнцвэржүүлж байгуулъя гээд судалгаанууд хийгдсэн. Эдний байгууллагууд нэлээн удаан хийгдсэн зүйлүүд байгаа.

Ингээд Улаанбаатар хотод шүүх ямар зарчимтай байх вэ гэдэг дээр ер нь ярилцаж байгаа. Бид саявтар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдтэй бүрэн бүрэлдэхүүнээр нь уулзалт хийсэн. Одоо бид ирэх долоо хоногт энэ нэг асуудлаас гайгүй жоохон намжуу болохоор уулзалт хийгээд нэлээн нарийвчилж деталь ярих гэж байгаа. Д.Ганбат гишүүн ээ.

Тэгээд бид өмнө нь таныг Хууль зүйн байнгын хорооны дарга байх үед эхлүүлсэн тэр шүүхийн нэгдсэн байрны тэр юуг цаашид Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар үргэлжлүүлж хийе. Өөрөөр хэлбэл хоёр талдаа эрүүгийн болон иргэний ийм шүүхийн төвлөрсөн байр байя. Хэргүүд нөгөө random_[санамсаргүй, тохиолдлын] байдлаар олон шүүгч дээр хуваарилагдаж тохиолдлын журмаар хэрэг хуваарилагддаг тогтолцоог илүү боловсронгуй болгоё.

Сая өнгөрсөн долоо хоногт батлагддаг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг шүүх дээр хэрэгжүүлье. Яагаад заавал төр өөрөө худалдаж авах ёстой гэж.

20, 30 жилээр түрээсэлж болно. Гол нь шүүхийн байр гэдэг бол шударга ёсны өргөө гэдэг агуулгаараа хүүхэд, залуучууд очдог хамгийн гоё архитектуртай зай талбайтай, үзэж харах юмтай ийм байр байх зориулалтаар бид ийм хөтөлбөр гаргаж ажиллая гээд яаман дээр бас нэг тодорхой судалгааны ажлууд хийгдээд явж байгаа.

Тэгэхээр одоогийн байгаа шүүхийн байрууд бол үнэхээр тэр шүүн таслах үйл ажиллагаа явуулж, шүүх үйл ажиллагаа явуулах ямар ч нөхцөл бололцоог хангахгүй байгаа. Юун хүүхдүүд очиж экскурс хийж, шударга ёсны өргөөтэй танилцана гэдэг ийм боломжгүй байгаа.

Тэгэхээр бид яг энэ чиглэл рүү шүүхийг шинээр эмхлэн байгуулах, түүнтэйгээ уялдсан шүүхийн байр байшин савыг бэлтгэх, материаллаг баазыг бэхжүүлэх тал дээр тодорхой хөтөлбөр, хуулийн төслүүдийг Засгийн газраас оруулж ирэхээр төлөвлөж ажиллаж байгаа гэдгийг Хууль зүйн байнгын хорооныхоо гишүүдэд энэ дашрамд хэлэхийг хүссэн юм.

Л.Мөнхбаатар: Гишүүд тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо санал хураалт явуулна. Энэ санал хураалт явуулахын өмнө нь зарчимын зөрүүтэй санал гишүүд гаргасан байна. Үүнийг танилцуулъя.

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх Шүүгч “10” гэснийг “18” гэж өөрчлөх, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх Шүүгч “11” гэснийг “15” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Ганбат гэсэн байна. Саналаа тайлбарлаж үг хэлэх үү? Б.Пүрэвдорж гэсэн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Монгол Улсын шүүх нийтдээ 699 шүүгч байгаа.

699 шүүгчийн орон тооны нийт дүнд, энэ тогтоолд зарчмын зөрүүтэй санал гаргаснаар өөрчлөлт орохгүй.

Хамгийн гол нь ачаалал багатай, дээрээс нь шүүгч дахиад энэ шүүгчийн орон тоо дутуу байгаа. Түүнээсээ хүн томилох замаар энэ асуудлыг шийдэх боломжтой гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарх нь, Чингэлтэй дүүрэг бол нэг шүүгчид оногдох хэргийн тоо 425 байна шүү дээ. Тийм. Судалгааных нь дагуу хэлж байгаа. Сая та нарт бүрэн хариулж өгсөн.

Тэгээд Хан-Уул дүүрэг бол 362 хэрэг шийдвэрлэж байгаа. Энэ бол маш их ачаалалтай ажиллаж байна гэсэн үг.

Тэгэхээр “10” гэдэг нь “15” болгож Шүүхийн ерөнхий зөвлөл оруулж ирж байгаа. Түүнийг нь “18” болгох ч юм уу, ийм байдлаар л “3” орон тоо нэмэгдүүлэх энэ саналыг гаргасан байгаа.

Ингэснээр иргэдэд хүрэх үйлчилгээ, өөрөөр хэлбэл шүүх дээр бүх асуудал нь гацаад нэг жил, хоёр жил болдог энэ зүйл маань илүү хурдан шуурхай шийдвэрлэх ийм боломж бүрдэнэ гэсэн үг.

Ялангуяа Хан-Уул дүүргийн шүүхийн хувьд тэнд аж ахуйн нэгжүүд маш их олонтой. Тийм ээ. Б.Энх-Амгалан гишүүн ээ. Тийм учраас энд жижиг аж ахуйн нэгжүүд том дүнтэй биш ч гэсэн бас жижиг аж ахуйн нэгжүүд маш их байдаг учраас энэ хэрэг маргааны асуудал маш их байдаг. Тийм учраас энэ саналыг маань дэмжиж гишүүд санал өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энэ тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тухай төсөл дээр Чингэлтэй дүүргийг “13” гэж орж ирсэн. Энэ дээр нь гишүүдийн саналаар 2-ыг нэмэхээр. Хан-Уул дүүрэг дээр “15” гэж орж ирсэн. Үүн дээр нь нэмэх нь “3”-ыг нэмнэ гэсэн.

Ингээд нийтдээ 5 шүүгчийн орон тоог нэмэх саналыг Байнгын хорооны гишүүд гаргаж байна.

Санал гаргахын өмнө Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн ажлын хэсэг хариульъя. Б.Ундрах.

Тэгээд 5-аар нэмээд явах боломжтой юу гэж үзэж байна шүү дээ. Гишүүдийн асуулт. Болно гэх юм бол Байнгын хорооны гишүүдийн саналаар санал хураагаад нэмнэ.

Тэгэхээр “19” биш “24” болно гэсэн үг байна. Тийм ээ. Энэ зохицуулалтыг хийх боломж ерөнхий зөвлөлд байгаа юу гэдэг асуултыг асууж байна. Б.Ундрах гишүүн асуултад хариульъя.

Б.Ундрах: Сая санал гаргаснаар Чингэлтэй дүүрэг дээр “2”, Хан-Уул дүүрэг дээр “3” гэсэн зөв үү? Тийм ээ. Би зөв ойлгосон уу?

Тэгэхээр энэ бол аль аль газраас татах вэ гэвэл бид өөр санал давхар орж ирсний нэг нь энэ л дээ. Тэгэхдээ боломжтой. Тэр нь юу вэ гэхээр хэрвээ Чингэлтэй дээр хоёрыг нэмэх юм бол Ховд, Хэнтий хоёроос Иргэний шүүхээс тус бүр нэгийг, Хан-Уул дээр гурвыг нэмэх юм бол Өвөрхангай, Сүхбаатар, Увсаас тус бүр гурав гурвыг авахад бараг болно гэсэн үг.

Л.Мөнхбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөл боломжтой гэж үзэж байгаа юм байна.

Санал хураая. Сул орон тоо байгаа юм. Б.Пүрэвдорж гишүүнд үг өгье. Товчхон 1 минут шүү. Тэгээд санал хураалтаа явуулъя.

Б.Пүрэвдорж: Сая Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Б.Ундрах нэг зүйлийг хэллээ. Хаана хаанаас татахаа ярилаа.

Тэгэхээр Ховд аймаг бол маш их өндөр ачаалалтай ажилладаг учраас Та наадах Ховд гэж ярьдгаа болиорой. Би протоколд тэмдэглүүлж байгаа. Албан ёсны юм.

Бид тогтоолын төсөл хууль баталж болно. Тэрийг протоколд тэмдэглүүлсэн тэр зүйл тодорхой хэмжээгээр хууль хэрэгжих явцад үйлчилдэг ийм зүйлийг та мэдэж байгаа байх.

Тийм учраас үүнийг протоколд тэмдэглүүлж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Д.Ганбат гишүүн үг хэлье. Саналаа тайлбарлаж үг хэлнэ. 1 минут шүү. Д.Ганбат гишүүн 1 минутаг багтаагаад.

Д.Ганбат: Шүүхийн ерөнхий зөвлөл боломжтой гэдэг хариултаа өглөө. Энэ ч одоо зөв зүйтэй байх.

Би түрүүн тэмдэгтийн хураамжийг асуусан. Та бүхнээс. Ер нь тэмдэгтийн хураамжаар ачаалал нь мэдэгдэж байгаа юм. Ингээд 2021 онд гэхэд 16 тэрбум 258 сая 387 мянга 203 төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг төрийн санд оруулжээ.

Түүнээс хамгийн наад зах нь гэхэд Хан-Уул дүүргийн Иргэний анхан шатны шүүх 3 тэрбум 445 сая төгрөгийг оруулсан байна. Бараг л одоо энэ иргэний хэрэг маргааны 20, 30 хувийг нь оруулсан байна шүү дээ.

Тэгэхээр яалт ч үгүй нэмэхгүй бол тэнд Улаанбаатар хотын захиргаа нүүж очиж байна. Үүнээс гадна тэр ямар их машин тэрэг түгжрэлтэй байна вэ. Тэгээд иргэд чинь бухимдаад байна шүү дээ.

Хуулийн хугацаа бол 60 хоногийн хугацаанд шийдвэрлэх ёстой. Тэгээд 60 хоногийн хугацаанд шийдэхийн тулд тэр шүүгч нар чинь зүгээр нэг уншсан болоод л ингээд л өнгөрөөгөөд.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Д.Ганбат гишүүн саналаа тайлбарлаж үг хэллээ.

Би ерөнхий зөвлөлийнхнөөс хоёр зүйл асуугаад орхиё.

Ховд аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх орон тоо “5” гэсэн байна. Увс аймаг дээр мөн адил Иргэний хэргийн анхан шатны шүүх “5” гэсэн байна.

Энэ 5-аас одоо яг хэд ажиллаж байгаа гэсэн үг вэ? Одоогийн байдлаар. Одоо хасах гэж байна шүү дээ. Энэ дээр товчхон хариулчих. Хэн хариулах вэ? 3 номерын микрофон өгчихье. Ажлын хэсэг.

А.Насандэлгэр: Ер нь өшөө ч нэмээд гэдэг юм уу, сул орон тоо байгаад байгаа учраас үндсэндээ “213” сул оронтой байгаа гэсэн үг шүү дээ. “699”-д хүргэхийн тулд.

Одоо бид нар “486” шүүгч ажиллаж байна гэхээр. Тэгэхээр зэрэг энэ “213”-ыг бид нар ачаалалд нь үндэслээд л бас энэ сонголтоо хийгээд байгаа юм. Ховдоос битгий аваарай гэж байгаа юм. Ховдоос одоо юу гэдэг юм ачааллыг нь хараад л хамгийн бага гээд л бид нар явж байна шүү дээ.

Тэгэхээр зэрэг Ховдын ачаалал бол одоо жишээ нь Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 56 хэрэг шийдэж байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг бид эндээс 4 шүүгч байхад нэгийг нь авчихад тэнд бүрэлдэхүүн нь үлдэж л байгаа юм. Тэр сул орон тоог нь авч байгаа болохоос тэнд бүрэлдэхүүнд нөлөөлөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх асуудлууд үүсэхгүй юм. Нөлөөлөхгүй. Тэр зарчим ерөөсөө л энэ. Тийм.

Л.Мөнхбаатар: Ойлголоо. А.Насандэлгэр гишүүн их тодорхой хариулчихлаа шүү дээ. Боломжтой гэсэн хариулт өглөө.

Ингээд санал хураалтыг явуулъя. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Ганбат нарын саналын томъёоллыг түрүүн уншиж танилцуулсан. Уг саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

Хуралдаанд оролцсон гишүүдийн 64.3 хувь нь дэмжсэн байна.

Уг санал дэмжигдлээ. Ингээд энэ тогтоолын төслийг Хууль зүйн байнгын хорооноос боловсруулж оруулж байгаа учраас Д.Ганбат, Б.Пүрэвдорж нарын гишүүдийн саналыг оруулаад нэгтгээд энэ саналаа хураачихъя.

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж батлуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

Хуралдаанд оролцсон гишүүдийн 76.9 хувь нь уг саналыг дэмжсэн байна. Санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Д.Ганбат гишүүнд танилцуулах уу? Хэн танилцуулах вэ? Д.Ганбат гишүүн танилцуулъя.

Уг дүгнэлттэй холбогдуулан Ц.Мөнх-Оргил гишүүн товчхон үг хэлье гэж байна.

Ц.Мөнх-Оргил: Би бас протоколд нэг юм тэмдэглүүлчихье. Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөнд хандаад.

Та хэд энэ ажлын байрны зураг авалт хийсэн гээд тэгж байна шүү дээ.

Тэгэхээр 486 хүн ажиллаж байна. 2023 оны төсөв дээр чинь 560 хүний орон тоо байна. Нийт 74 хүний орон тоо цаана нь байна шүү дээ. Тэгэхээр үүнийгээ ачаалалтай нь тэнцүүлээд тэр Сүхбаатар дүүрэг, Хан-Уул, өөр юу байдаг юм, яг тэр нөгөө ажлын байрны зураг авалтдаа нийцүүлээд та хэд 2023 онд оруулж ирэхээр нэг бэлтгэл хангаадахаач. Тэгэх үү.

Одоо бол ингээд гал унтраагаад яаралтай юмнуудаа ингээд шийдээд явчихъя. 2023 онд энэ 560 хүний орон тооныхоо төсөв дээр суурилоод зураг авалтдаа тулгаад ачааллыг тэнцүүлэх хэлбэрээр санал бэлдээд ороод ирээч ээ.

Л.Мөнхбаатар: Шүүрхий зөвлөл, ажлын хэсгийнхэн Ц.Мөнх-Оргил гишүүний саналын дагуу уг асуудлыг боловсруулаад Хууль зүйн байгын хороонд танилцуулъя.

Уг санал дэмжигдсэн. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдэд баярлалаа.

Хоёр.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.10.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд оръё. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Шатарбалын Раднаасэд танилцуулна. Ш.Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Ажлын хэсэг Ш.Раднаасэд, Ш.Адъяаа, Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, Ц.Сандаг-Очир гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан.

Ажлын хэсгийн хурлаар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг яриад өмнөх Байнгын хороо хэлэлцэх эсэх дээр Байнгын хороо болон чуулган дээр гарсан гишүүдийн саналыг бас онцгой анхаарч хэлэлцсэн байгаа.

Ингээд нийтдээ зарчмын зөрүүтэй 7 санал боловсруулсан. Хуулийн төслийг нэлээн засаж сайжруулах хэлбэр лүү.

Гол нь хуучин төсөл дээр байсан тэр тэмдэгтийн хураамжийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хөрөнгийг дараа жилийн төсөвт авна гэдэг зүйлийг өөрчилсөн байгаа. Энэ бол зайлшгүй. Уг нь яг байгууллагын эрх ашигтаа хэрэгтэй байдаг. Гэхдээ ингэж төсвийн орлогыг төсвийн хуулиас гадуур дахиж хуваарилалтын зарчмаар хийх нь, хувь зааж явах нь бас буруу юм гэсэн байдалтай.

Хоёрдугаарт нь, шадар зөвлөх гээд төрийн тусгай албан хаагч болж байгаатай холбоотой бас цолны асуудал явагддаг. Үүнийг нийтдээ өнөөдөр Монгол Улсын яг ижил түвшний гэдэг юм уу, үндэсний аюулгүй байдлын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа хил, гааль дээр ажилладаг, одоо энэ нэг ижил хүчний төрийн тусгай албадын байгууллагуудтай харьцуулж үзэж энэ зөвлөхийн цолны асуудал дээр бас зарим нэг цолыг нь хасаж өөрчилж шинэчилсэн байгаа.

Гол зарчмын юм нь бол тийм. Бусад нь үг үсэг, найруулгын шинжтэй зүйлүүд байсан. Тайлбар гэдэг зүйл. Нэлээн хураангуйлсан бөгөөд бас нэлээн ойлгомжтой, тодорхой болгож өгсөн. Үг хэллэг, бусад найруулга байвал бусад хууль тогтоомжтой нийцүүлэх юмнуудыг нь засаж тэгшилж ингэж орсон байгаа.

Хуулийг 03 сарын 01-ний өдрөөс эхэлж дагаж мөрдье гэсэн ийм байдлаар саналын томьёолол бэлдсэн.

Ингээд Та бүхнийг Байнгын хорооны хуралдаанд хэлэлцэж дэмжиж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Ш.Раднаасэд гишүүнд баярлалаа.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдээ танилцуулъя.

Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Гадаад иргэн, харьяатын газрын Захиргаа, удирдлагын газрын дарга Д.Мөнхбаатар, Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Солонго, Гадаад иргэн, харьяатын газрын Хуулийн мэргэжилтэн Б.Эрдэнэбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Т.Нарантунгалаг нар оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Ц.Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Ц.Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнх-Оргил: Асуулт байхгүй ээ. Би сая ажлын хэсэг дээр цөөнх болсон юм.

Би 1 дүгээр зүйлийг ер нь бүхэлд нь хасъя гэсэн саналтай байгаа юм. Энэ дээр яах вэ, жоохон нэлээн өөрчлөөд оруулаад ирсэн л дээ. Ер нь хуулийн төслийг би дэмжиж байгаа юм. Төрийн тусгай алба болгоё. Төрийн тусгай албан хаагч болгоё гэдэг саналуудыг дэмжиж байгаа юм.

Гэхдээ ингэх ялдамдаа Төсвийн хуулийнхаа ерөнхий зарчмуудыг хөндөөд байж боломгүй байгаа юм. Ерөөсөө төсөвтэй холбоотой харилцаа чинь Төсвийн хуулиараа л явна. Тэгэхгүй хэдүүлээ ингээд л нэг байгууллагын асуудал ороод ирэхээр л яг тэр байгууллагынхантай тэр салбарынхныхаа ажлынх нь зовлон, ач холбогдол бүгдийг нь ойлгоод л ерөөсөө ямар хэцүү юм гээд л. Тэгээд л нөгөө зарчмаасаа ухраад л, байгууллага болгонд зориулсан төсвийн ч юм уу, нийгмийн халамжийн тус тусад нь ингээд л ёлкны модон дээр чимэг өлгөж байгаа юм шиг л эрх зүйн орчноо янз янз болгоод байж боломгүй байгаа юм.

Тэгээд анх өргөн барьсан санал нь Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10.6 дахь хэсэгт заасан нөгөө хураамжийг төсөвт төвлөрүүлнэ шүү дээ. Тэгэхдээ мөнгөн дүнгийн 20 хувийг нь байгууллагад нь ерөөсөө шууд өгч бай гэсэн заалт орж ирэхгүй юу. Тэгээд энэ бол байж болохгүй юм. Төсвийн асуудал бол төсвөөрөө л явна. Нэг л хуулиар зохицуулагдана. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ингээд нөгөө хураасан мөнгөнөөс нь байгууллага чинь үлдээнэ шүү гээд байхаар байгууллагууд, албан хаагчид ерөөсөө нөгөө торгууль тавих сонирхол, сэдэл үүсээд байгаа байхгүй юу. Нөгөө 20 хувь нь буцаад өөрт нь ороод ирж байгаа учраас байгууллагын удирдлага ч сонирхолтой, байгууллагын ажилтнууд нь сонирхолтой. Тэгээд ерөөсөө уралдаан зарлачихдаг.

Тэгээд ингэж болохгүй юм. Тэгээд би бол бүхэлд нь хасъя гэсэн саналтай байгаа юм. Тэгээд үүнийг манай ажлын хэсэг дээр цөөнх болоод ажлын хэсгийн олонх нь юу гэж үзсэн бэ гэхээр цахим виз, оршин суух үнэмлэх хэвлэх үйлчилгээний хөлсний орлогыг байгууллагын цахимжуулалт, мэдээллийн технологийн шинэчлэл, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зориулан дараагийн жилийн төсөвт суулгаж санхүүжүүлнэ гээд арай зөөлчиж байгаа юм. Гэхдээ зарчим нь хэвээрээ.

Төсөвт юу суухыг дахиад л бид энэ харьяатын хуулиар заагаад өгчхөж байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг бүхэлд нь хасчихъё. Гарцаагүй зардал хөрөнгөтэй байх юм бол тэрийг төсвийнхөө хуульд оруулаад л, Х.Нямбаатар сайд оруулаад ирнэ, Засгийн газар оруулаад ирнэ. Бид батлаад л өгнө шүү дээ.

Бид гарцаагүй шаардлагатай байлаа гэхэд нэг их. Их Хурал дээр тэр байгууллагуудын төсөв нэг их хасагдаад байдаг юм байдаггүй шүү дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ерөөсөө хэдүүлээ энэ эрх зүйн зохицуулалттай зарчимдаа баригдаж л амьдармаар байна. Түүндээ захирагдаж л энэ хуулиудаа хиймээр байна. Харьяатын албаны хууль бол харьяатын албадтайгаа л холбоотой асуудлаа л зохицуулаад л явъя. Төсөв мөнгөтэй холбоотой асуудлаа төсөв мөнгөнийхөө хуулиар л явъя.

Тийм учраас би үүнийг хасъя гэсэн саналтай байгаа юм.

Л.Мөнхбаатар: Үг хэлж дууслаа. Сая санал хэлчихлээ шүү дээ. Асуулт асуугаагүй. Б.Пүрэвдорж гишүүн асуулт асууна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 2012 онд энэ байгууллагын даргаар би очиж байсан л даа. Тэгэхэд энэ байгууллага 2 хуультай, 86 журамтай байсан юм.

86 журмаар нь байна шүү дээ баахан эрх мэдлийг төвлөрүүлчихсэн. Тэгээд ерөөсөө тэр Цагааннуурын боомтоор орж ирж байгаа цистерын жолоочийн олон удаагийн визийг хүртэл газрын дарга нь гарын үсэг зурж байж өгдөг ийм бюрокрасы тэнд бий болчихсон.

Ийм юмыг нь байхгүй болгоод 86 журмаас би 51 хувийг нь журмуудыг нь бүгдийг нь хүчингүй болгоод 44 журмыг нь хүчингүй болгосон. Ж.Сүхбаатар аа. 44 журмыг нь хүчингүй болгосон юм.

Тэгээд манай байгууллага байна шүү дээ. Одоогийн байдлаар миний тэр журамд өөрчлөлт оруулснаар байна шүү дээ энэ байгууллага журмаараа нэг ч эрхгүй ажиллаж байгаа. Дандаа үүрэгтэй ажиллаж байгаа. Тэгж өөрчилсөн байсан. Одоо хэвээрээ байгаа гэж найдаж байна.

Тэгээд энэ журмууд дээр юу өөрчилсөн бэ гэхээр тэр дарга гарын үсэг зурж виз өгдөг байсан юмыг бүгдийг нь тэр Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу хил дээр ажилладаг мэргэжилтэн, байцаагч виз олгодог болгосон байхгүй юу.

Тэгээд энэ байгууллага 4 тэрбум төгрөгийн орлого олдог байгууллага энэ дүрэм журмын өөрчлөлтөөр 13 тэрбум төгрөгийн орлого олдог байгууллага болж хувирсан юм.

Хүнд суртлыг халахад ийм үр дүн бий болдог. 3 дахин нэмэгддэг. 3.5 дахин. Тэгээд 2015 онд би явсан. Би явснаас хойш буцаад 4 тэрбум төгрөгийн орлого олдог байгууллага болсон байгаа. Өөрөөр хэлбэл тэнд виз авдаг, олгодог тэр процесс дээр хүнд суртлаа буцаагаад бий болгочихсон гэсэн үг байхгүй юу даа. Ийм л юм байгаа юм.

Тийм учраас бид энэ аялал жуулчлалаа нэмэгдүүлмээр байдаг. Илүү визийг нь хүндрүүлэх хүндрэл бий болгох замаар тэнд ажилладаг хүмүүс орлоготой болох

биш илүү энэ виз нь хөнгөлөлттэй байгаад орлого нь тэр байгууллагад хангалттай ороод тэрний дагуу төсөв нь ч нэмэгдэж байдаг, дээрээс нь аялал жуулчлалын дагуу бүх бизнес Монгол Улсын орлого нэмэгдэж байдаг ийм л зүйлийн төлөө би үүнийг хийсэн юм л даа.

Тэгээд энэ орлого улсын төсөвт ордоггүй юм шүү. Улсын төсөвт ордоггүй. Энэ орон нутгийн төсөвт ордог. Орон нутгийн төсөвт ордог. Хураамж шимтгэл чинь улсын төсөвт ордоггүй шүү дээ. Орон нутгийн төсөвт буюу Хан-Уул дүүрэг, аль эсвэл Ховд аймагт орсон, эсвэл Дорноговь аймагт тэнд ордог байхгүй юу даа.

Тэндээс тодорхой хураамжийг л төвлөрүүлэх тухай асуудал. Энэ хүмүүсийг илүү юу яадаг юм, үйлчилгээг нь сайжруулах замаар илүү орлогыг нь нэмэгдүүлэх тэр процессыг л хийж өгч байгаа юм. Бусдаар нөгөө орлогын төлөө ажилладаг. Тэгээд бас энэ үйлчилгээгээ сайжруулах замаар ажилладаг тэр байгууллагыг дэмжиж ажилласнаар илүү Монголд хэрэгтэй болохоос биш илүү тэр нөгөө нэг хаалттай байдлаар хүн амьтанд үйлчилдэггүй ийм байдлаар Монголоо ч хохироогоод, энэ бизнесээ ч хохироогоод байдаг ийм зарчмыг бид халах ёстой байхгүй юу. Тэгэхэд үүнийг хийж байгаа тэр хүмүүсийг бас үйл ажиллагааг нь урамшуулах энэ ажлыг хийх ёстой.

Сүүлийн үед үнэхээр энэ гадаадын харьяатын байгууллага бол үйлчилгээ нь маш сайжирсан. Хүмүүс магтаад ярьж байна лээ. Дээрээс нь цахим виз энэ тэр гээд маш сайн технологийн хөрөнгө оруулалтуудыг хийсэн.

Ажил нь сайжирч байгаа. Янз янзын хэл ам миний чихний хажуугаар ерөөсөө өнгөрдөггүй байсан. Одоо бол ямар ч асуудалгүй болчихсон байгаа.

Тийм учраас энэ үйлчилгээг нь сайжруулаад тэгээд та нарын төсөв гэж яриад байх юм. Энэ чинь ерөөсөө тэр Б.Жавхлангийн төсвийн тухай асуудал огт биш шүү.

Орон нутагт тэр суманд нь орж байгаа, аль эсвэл Замын-Үүд суманд орж байгаа, аль эсвэл юу байдаг юм тэр Ховдын Булган суманд орж байгаа тэр төсвийн тухай асуудал ярьж байна. Тэндээс 20 хувь төвлөрүүлэх тухай асуудал байхгүй юу даа.

Л.Мөнхбаатар: Б.Пүрэвдорж гишүүн үг хэллээ.

Ингээд ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураая. Санал хураалт явуулъя.

Энэ асуудлыг санал хураалтаараа шийднэ. Байнгын хорооны гишүүд өөрийнхөө байр суурийг өөрийнхөө итгэл үнэмшлээр санал хураалтаараа шийдээд явах нь зүйтэй. Гишүүд суугаарай.

Би ажлын хэсгийн саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Санал хураалт явуулъя. Гишүүд суу.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 40.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.3.Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн цахим виз, оршин суух үнэмлэх хэвлэх үйлчилгээний хөлсний орлогыг байгууллагын цахимжуулалт, мэдээллийн технологийн шинэчлэл, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.”

Санал хураалт. Ажлын хэсэг саналаа нэгтгэж орж ирсэн байх ёстой. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

Уг санал хуралдаанд оролцсон гишүүдийн 69.2 хувийн саналаар дэмжигдсэн байна.

Дараагийн санал хураалт.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 41.1 дэх хэсгийг доор дурдсаар өөрчлөн найруулж, 41.1, 41.2 дахь хэсэг болгох:

“41.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хууль болон холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангахад төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллага мөн.

41.2.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь төрийн тусгай албан хаагч байна.” Санал хураалт.

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 61.5 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн тайлбарыг хасах. Санал хураалт.

Уг саналыг 53.8 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдлээ.

Дөрөв. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.14.2 дахь заалтын “шадар зөвлөх” гэснийг “эрхэлсэн зөвлөх” гэж, 41.14.3 дахь заалтын “жинхэнэ зөвлөх” гэснийг “ахлах зөвлөх” гэж өөрчилж, 41.14.4 дэх заалтыг хасах. Санал хураалт.

Санал хураалтыг цуцалъя. Санал хураалтыг цуцалъя. Б.Энх-Амгалан гишүүн асуулт асууя. Б.Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: Хуулийн үзэл баримтлал дээр байсан нөгөө 6 цаг хүн саатуулна, гадаадын иргэдийн эрх зүйн байдлын хуульд заасны дагуу хяналтын улсын байцаагчтай байна. Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэнэ барина гээд нэг ийм зохицуулалт ороод ирчихсэн байсан. Тэр нь одоо яг хэвээрээ явж байгаа юу?

Одоо энэ дээр нөгөө нэг эрхэлсэн зөвлөх гээд нэг тийм юм хасагдаж байгаа юм байна. Тэр нөгөө нэг байцаагч гээд л нэг 6 цагийн эрхэм эрхтэй. Тэгээд цол авдаг тэр юм нь яг хэвээрээ үлдсэн үү. Тийм ээ. Тэрийг найруулж өгөөч.

Анхны үзэл баримтлал дээр байсан. Хил дээр 6 цагийн саатуулна, яана, ийнэ. Тийм эрхтэй. Тусгай хэрэгсэл хэрэглэнэ, мэх хэрэглэнэ. Цол авна гээд юмнууд.

Л.Мөнхбаатар: Тийм зүйл байхгүй шүү дээ.

Б.Энх-Амгалан: Тэр байхгүй юу? Тийм ээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Ш.Раднаасэд хариулчихъя. Асуултад.

Ш.Раднаасэд: Энэ бол төрийн тусгай албан хаагч болсонтой холбоотой цолны л юм байгаа. Энэ дээр бол.

Тэр нэг тусгай хэрэгсэл хэрэглэнэ гэдэг чинь энэ дотор ерөөсөө байхгүй. Одоо бол мөрдөж байгаа хуулийн дотор байгаа шүү дээ. Зүгээр тэрний дугаарыг л хөдөлгөж байгаа. Энэ бол арай өөр. Энэ чинь төрийн тусгай албан хаагчтай бүх байгууллагууд цолтой байдаг учраас тэрийг дүйцүүлж л үүнийг оруулж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Саналын томъёоллыг уншсан. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 69.2 хувь нь дэмжсэн байна. Санал дэмжигдлээ.

Тав дахь санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.16 дахь хэсгийн “цолд хамаарах албан тушаалын ангилал,” гэснийг хасах. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 76.9 хувь нь уг саналыг дэмжсэн байна.

Зургаа. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 41.17 дахь хэсгийн “Албан хаагчийн” гэснийг “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн” гэж, “мэргэжлийн, эрдмийн” гэснийг “докторын, мэргэжлийн” гэж өөрчилж, “нэмэгдлийн” гэснийг хасах. Санал хураалт.

Уг санал хуралдаанд оролцсон гишүүдийн 69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Санал гараагүй байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй нэг санал байна. Санал хураалт явуулъя.

Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалт.

Уг саналыг 69.2 хувийн саналаар уг санал дэмжигдсэн байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын саналаар хураалтыг явуулъя.

Найруулгын саналыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 40.3 дахь хэсгийн “иргэн, харьяатын” гэснийг “иргэний” гэж, 41.18 дахь хэсгийн “оногдуулах” гэснийг “ногдуулах” гэж, 3 дугаар зүйлийн “Улсын байцаагч” гэснийг “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч” гэж, “41.7.2.” гэснийг “41.8.1.” гэж, “41.7.3” гэснийг, “41.8.2.” гэж, “41.7.4.” гэснийг “41.8.3.” гэж, “41.7.6.” гэснийг “41.8.4.” гэснийг, “41.7.2.” гэснийг, “41.8.2.” гэж, “41.7.3.” гэснийг “41.8.3.” гэж, “41.7.4.” гэснийг “41.8.4.” гэж, “41.7.6.” гэснийг “41.8.6.” гэж өөрчлөх. Санал хураалт.

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 76.9 хувь нь дэмжсэн байна.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, ишлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт.

Б.Пүрэвдорж гишүүн өөрийнхөө хуульд саналаа өгөөрэй. Санал хураалт явж байна шүү.

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 75.9 хувь нь дэмжсэн байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Гадаад иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг санал байна. Зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт, 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийн “төрийн тусгай хамгаалалт,” гэсний дараа болон 57.5.4 дэх заалтын “гаалийн байгууллагын ажилтан” гэсний өмнө “гадаадын иргэн, харьяат,” гэж, 13.1.6 дахь заалтын “шинжээч, мэргэжилтэн” гэсний дараа “,гадаадын иргэн, харьяатын байгууллагын ажилтан” гэж нэмэх.” Санал хураалт.

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 76.9 хувь нь дэмжсэн байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгээс гаргасан санал алга байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ш.Раднаасэд танилцуулна.

Дараагийнхаа асуудалд орьё.

Гурав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд орьё. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийг оруул. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Баасандорж оролцож байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд оролцож байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрх зүй, эрсдэлийн удирдлагын газрын дарга Ч.Ариунхур, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хуулийн ахлах мэргэжилтэн Ё.Отгонжаргал нар уг хуралдаанд оролцож байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Б.Пүрэвдоржоор тасаллаа. Б.Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Маш богинохон асуучихъя. Зөрчлийн тухай хууль 2017 оноос хэрэгжиж эхэлсэн.

Тэгэхээр яг энэ зөрчил хариуцсан прокурорын хүн сууж байна. 2017 оноос 2017, 2018, 2019, 2020, 2021 гээд 2022 хэрэггүй. Энэ онууд хэдэн зөрчил давхардсан тоогоор шийдвэрлэгдсэн, хэдэн төгрөгийн торгууль ногдсон. Маш хурдан хэлээд өгчих.

Л.Мөнхбаатар: Б.Пүрэвдорж гишүүд асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсэг. 3 номерын микрофоныг өгье. Ц.Батболд дарга хариулъя.

Ц.Батболд: 2017 оноос хойш Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байгаа.

Энэ мөрдөж эхэлснээс хойш зөрчлийн шалган шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн бүртгэлийн прокурорын байгууллага хөтөлж явж байгаа.

Өнөөдрийг хүртэл явж байгаа. Яг өнөөдрийн энэ юун дээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой 1.8 дугаар зүйлд заасан харьяаллын

асуудал яригдахтай холбоотой ажлын хэсэгт орж ирж байгаа учраас яг өнөөдрийн байдлаар статистик тоог би энд орж ирээгүй нь уншаарай. Би эргээд танд тоо бүртгэл мэдээллийн талаар дэлгэрэнгүй судалгааг хүргүүлье.

Л.Мөнхбаатар: Санал хураалт. Энэ ингэж байгаа. Б.Баасандорж дарга аа. Хуулийн төслийнхөө талаар нэг товчхон та гишүүдэд нэг ойлголт өгөх мэдээлэл өгчих. Тэгээд санал хураалтуудаа явуулчихъя.

Б.Баасандорж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар. Б.Баасандорж.

Сая 2022 оны 11 сарын 11-ний өдөр Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсан. Энэ Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан хамт Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт ороод мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэг салбарын яамдад шилжсэн байгаа.

Яг үүнтэй холбоотойгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт өргөн мэдүүлсэн. Тэгээд Хууль зүйн байнгын хороон дээр 12 сардаа багтааж 01 сарын 01-нээс өмнө батлаарай гэж үүрэг өгсний дагуу одоо манай дээр харьяалан шалгагдаж байгаа Зөрчлийн тухай хуулийн 102 зүйлийн 525 хэсэг, 887 заалтад хамаарах зөрчилд Мэргэжлийн хяналтын байгууллагын 879 эрх бүхий албан тушаалтны зөрчил шалгадаг байгаа.

Яг энэ 27 чиглэлийг л салбар салбарт нь байцаагч нарт нь чиглэл чиглэлийг нь өгч байгаа. Өөр өөр маш товчхон хэлэх юм бол Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, мэргэжлийн хяналтын байгууллага гэж харьяалуулсан байсан хяналтуудыг л байгаль орчныг нь байгаль орчинд нь, хүнсийг хүнсний яаманд нь, эрүүл мэндийг эрүүл мэндийн яаманд өгч байгаа юм. Салбар салбарт. 28 салбарт.

Л.Мөнхбаатар: Мэргэжлийн хяналтын чиг үүргийг л яамдад хуваарилж байгаа л асуудал байгаа шүү дээ. Тийм ээ. 28 чиглэлийн ийм чиг үүргийг холбогдох байгууллагууд нь хуваарилж байгаа.

Санал хураалтыг явуулъя. Ажлын хэсгээс. Ц.Сандаг-Очир гишүүн санал гаргах юм уу? Ц.Сандаг-Очир гишүүний зарчмын зөрүүтэй санал байгаа. Энэ саналыг танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.34, 6.35, 6.36, 6.37, 6.38, 6.39, 6.40, 6.41, 6.42, 6.43, 6.44, 6.45, 6.46, 6.47, 6.48, 6.49, 6.50, 6.51, 6.52, 6.53, 6.54, 6.55, 6.56, 6.57, 6.58, 6.59, 6.60 дахь заалт нэмсүгэй:

6.34.авто замын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 10.30, 11.2, 14.4, 14.5 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.35.автотээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 14.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.36.байгаль орчны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 2.1, 2.2 дахь заалт, 3, 4, 5, 6 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 4, 5, дахь хэсэг 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7 дахь заалт, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28 дахь хэсэг, 6.24 дүгээр зүйл, 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.37.барилгын техникийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 7.7 дахь заалт, 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 16.5 дахь заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 10.30, 11.2, 12.1, 12.4, 12.5, 12.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.38.боловсролын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.19 дүгээр зүйл, 9.1, 9.2, 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 9.9 дүгээр зүйл, 9.10 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, 3 дахь хэсэг, 9.11, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил;

6.39.газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулин 7.1 дүгээр зүйл, 7.2 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 8.1, 8.2 дугаар зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 10.30, 11.2, 12.2, 12.3, 12.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.40.газрын тос, хийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.13 дугаар зүйлийн 3, 7, 8 дахь хэсэг, 16.5 дахь заалт, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2.2, 2.3, 2.4, 2.5, 3.1, 3.3 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.41.геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.12 дугаар зүйл, 5.15 дугаар зүйлийн 1.2, 1.4 дэх заалт, 2 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 8 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 9.7 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.42.мал үржлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.43.мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11 дэх дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 4, 5 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4 дүгээр зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 13.5, 13.9 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.44.нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.17, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.45.соёлын хяналтын улсын байцаагч Зөрчийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 9.5, 9.6 дугаар зүйл, 9.7 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14 дэх хэсэг, 9.12, 9.13 дугаар зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.46.соёлын өвийн хяналтын улсын байцаагч зөрчлийн тухай хуулийн 9.7, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.47.ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 13.1, 13.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.48.усан замын тээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.49.харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.22, 10.25, 10.27, 10.29, 10.30, 11.2, 14.1, 14.2, 14.3, 14.13 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчил;

6.50.хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.2, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.51.хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Зөрчийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 10.12, 10.13, 10.14 дүгээр зүйл, 10.15 дугаар зүйлийн 5 дахь

хэсэг, 10.16, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.52.хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.15, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.53.хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.3 дугаар зүйлийн 2.3, 2.4 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 14, 15, 16 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.16 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, 6.25 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25, 13.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.54.хэмжил зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.24, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.55.цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 12.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.56.эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 1.2, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.9 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг заасан зөрчил;

6.57.эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.8, 6.9 дүгээр зүйл, 6.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 6 дахь хэсэг, 6.11 дүгээр зүйл, 6.7 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсэг, 9.2, 9.4 дэх заалт, 6.9 дүгээр зүйл, 6.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 6 дахь хэсэг, 6.11 дүгээр зүйл, 6.28 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.58.эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6 дахь заалт, 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 3, 6 дахь хэсэг, 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6 дахь заалт, 8, 9, 10, 12, 13, 14, 15, 17, 18, 19, 20,23, 26 дахь хэсэг, 6.2 дугаар зүйлийн 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг, 6.3 дугаар зүйл, 6.4 дүгээр зүйлийн 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.7, 2.9 дэх заалт, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11, 16 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.9 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэг, 6.12

дугаар зүйл, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.17 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1.1, 1.5 дахь заалт, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 6, 8 дахь хэсэг, 9.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4 дүгээр зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 1.9, 6.1, 7.2 дахь заалт, 12.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12.5 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.59.эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.19, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.60.эрчим хүчний хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 10.30, 11.2 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 7.2 дахь заалт, 12.8, 12.9, 12.10, 12.12 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.” Санал хураалт. Гишүүд ээ, санал хураалт. /алх цохив/

Б.Пүрэвдорж гишүүн горимын санал гаргая.

Б.Пүрэвдорж: Санал хураалт болсонгүй. Тэгээд эхнээс нь дахиж уншаад дахиад санал оруулахыг хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Уг санал хураалтыг хүчингүй болгох сандралтыг явуулъя. Санал хураалт гишүүд ээ. /алх цохив/

Уг саналыг санал хураалтад оролцсон гишүүдийн 58.3 хувь нь дэмжсэн байна.

Санал хураалтыг явуулъя. Өмнө нь томъёоллыг уншсан. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад оролцсон гишүүдийн 58.3 нь уг саналыг дэмжсэн байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Ц.Сандаг-Очир гишүүний санал томъёоллыг танилцуулъя.

Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.11 дэх заалтын “6.1 дүгээр зүйлийн 27” гэсний дараа “, 28” гэж, 6.12 дахь

заалтын “7.5 дугаар зүйл,” гэсний дараа “7.10, 7.11, 7.12, 7.13,” гэж, “6.5 дугаар зүйлийн 10, 12,” гэсний дараа “13,” гэж, “6.17 дугаар зүйлийн” гэсний дараа “5,” гэж, “7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,” гэсний дараа “7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж, 6.14. дэх заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж тус тус нэмсүгэй.” Санал хураалт. /алх цохив/

Б.Энх-Амгалан гишүүн горимын санал гаргая.

Б.Энх-Амгалан: Сая миний төхөөрөмж ажилласангүй. Тийм учраас энэ санал хураалтыг хүчингүй болгож өгөөч ээ гэдэг горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Б.Энх-Амгалан гишүүний гаргасан горимын саналаар уг саналыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Уг санал 63.6 хувийн саналаар дэмжигдлээ. Уг санал хүчингүй боллоо.

Түрүүн өмнө нь уншсан саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Хуралдаанд оролцсон гишүүдийн 63.6 хувь нь уг саналыг дэмжсэн байна.

Дараагийн санал хураалт.

Төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.15 дахь заалтын “10.19 дүгээр зүйл,” гэснийг хассугай.” Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг 54.5 хувь нь дэмжсэн байна.

Дараагийн санал хураалт.

Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх.

“4 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг 63.6 хувь нь дэмжсэн байна. Уг дамжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Ц.Сандаг-Очир гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 63.6 хувь нь дэмжсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын Ц.Сандаг-Очир танилцуулна.

Дараагийнхаа асуудалд орьё.

Дөрөв.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар танилцуулна. Ж.Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн болно.

Хууль зүйн байнгын хороонд 2021 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж төсөлд тусгасан бөгөөд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт төслийг бэлтгэлээ.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх төслийг гишүүдэд тараасан байгаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асуусангүй.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийг эцсийн эсүүдэд бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулна.

Дараагийнхаа асуудалд оръё.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/

Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг Та бүхэн танд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Хуралдаад оролцсон гишүүдийн 70.0 хувь нь уг саналыг дэмжсэн байна. Тогтоолын төсөл батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД